
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭН ТАНИУЛАХ АЖЛЫН ГАРЫН АВЛАГА

*/Олон нийтийн болон төрийн бус байгууллагуудын
хэрэгцээнд зориулав/*



Гарын авлагыг боловсруулсан:

С.Оюунтуяа

/Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн/

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-аас үзүүлсэн Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Гарын авлагыг Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, АНУ-ын Азийн сан хамтран бүтээсэн бөгөөд гарын авлага нь АНУ-ын Засгийн газар болон ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

ГАРЧИГ

АГУУЛГА	3
ӨМНӨХ ҮГ	4
ГАРЫН АВЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?	6
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ	7
1.1. Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?	7
1.2. Ашиг сонирхлын зөрчил ба авлига	22
1.3. Ашиг сонирхлын зөрчлийн төрөл, хориглолт болон хязгаарлалт	28
ХОЁРДУГААР ХЭСЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО	47
2.1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь	47
2.2. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоо	63

ӨМНӨХ ҮГ

Жирийн иргэд төрийн байгууллага, албан тушаалтнаас шударга бөгөөд *өндөр* тогтоосон хэм хэмжээнд стандартад нийцсэн үйлчилгээг хүсэн хүлээдэг. Төрийн албан хаагч нь нэг талаас төрийн, нөгөө талаас иргэдийн итгэлийг хүлээх болдог. Иймээс төрийн албан тушаалтнуудын өдөр тутмын үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлийн олон хэлбэрүүдээс ангид байлгах асуудал нэн тулгамдсан асуудлын нэг байсаар байна. Төрийн албан тушаалтнууд албаны эрх мэдлээ олон нийтийн эрх ашгийн төлөө бус харин өөрийн болон өөрийн гэр бүл, ах дүү, ангийн найз нөхдийн төлөө урвуулан ашиглаж байгаа олон жишээ, баримт бидний дунд ам дамжин яригдсаар байдаг. Бусад улс орнууд ч өсөн нэмэгдсээр байгаа авлигын асуудлаа “төрийн эрх мэдлийг төрийн албан хаагч өөрийн ашиг сонирхолд урвуулан ашиглах” буюу төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчилтэй холбон тайлбарладаг.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтод төрийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх албаны чиг үүрэгтэй нь харшлахыг ойлгодог. Үүнээс байнга, бололцооныхоо хэрээр зайлсхийж, өөрийн болон төрийн байгууллагынхаа нэр хүндийг эрсдэлд оруулахгүй байх шаардлага төрийн албан тушаалтнуудад тавигддаг.

Манай улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид 2005 оны 4 дүгээр сарын 29-нд нэгдэн орсон. Энэхүү конвенциор ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгон хэрэгжүүлэх амлалт авсан. Энэ зорилтын хүрээнд 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг батлан, хэрэгжүүлж байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчил, нийтийн алба, нийтийн ашиг сонирхол, нийтийн албан дах ашиг сонирхлын зөрчил зэрэг нэр томъёо, тодорхойлолтууд нь ойлголтын болон хэрэглээний түвшинд шинэ зүйл юм.

Иймд ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг энгийн байдлаар, хялбаршуулан ойлгуулж, таниулах энэхүү гарын авлагыг төрийн бус байгууллага, иргэдэд зориулан боловсруулсан болно. Нийгмийн шударга ёсыг хамгаалах ажилд манлайлан оролцдог төрийн бус байгууллага, иргэдэд энэхүү гарын авлага хаяглагдсан. Учир нь, тэдгээрээс ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтыг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, төрийн байгууллагын ил тод, нээлттэй, тунгалаг байдлыг хөхүүлэн дэмжих, түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн итгэлийг хадгалж үлдэхэд хувь нэмрээ оруулахад нь хөтөч болгохыг зорьсон билээ.

Энэхүү “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага” нь нийгмийн шударга ёсыг хамгаалах үйлсэд томоохон хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

ГАРЫН АВЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Энэхүү гарын авлага нь 2 хэсэг бүхий 5 сэдэвтэй. Сэдэв тус бүр нь сэдвийн түлхүүр ойлголт, тухайн сэдвийг хэрэглэж болох тодорхой аргачлал, үндсэн ойлголт, мэдлэг өгөх хэсэг, сэдвийн талаар жишээ болон кейс, сургалтын үеэр ашиглаж болох дасгал ажлуудын жишээ, мөн тухайн сэдвийн хүрээнд хамаарах асуулт болон хариултыг багтаасан өргөн агуулгатай.

Гарын авлагаар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-тай холбоотой мэдээллийг сэдэв тус бүрт багтаан оруулсан. Зөвхөн хуулийн зохицуулалтаар хязгаарлалгүй ашиг сонирхлын зөрчлийн гол агуулга, зарчим, тодорхойлолт зэргийг ч мөн багтаав. Тухайн сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан мэдээллийг асуулт, хариултын хэлбэрээр оруулсан бөгөөд энэ нь хуулийн зохицуулалтын талаар мэдлэг олж авахад дөхөм болох болно.

Түүнчлэн, энэхүү гарын авлагыг сургалтын гарын авлага болгон ашиглах боломжтой. Сэдэв тус бүр дээр сургалтын үед ашиглаж болох дасгал жишээг оруулсан. Сургагч багш эдгээрийг улам баяжуулан өөрийн сургалтын арга барил, арга зүйдээ нийцүүлэн ашиглаж болно. Сургалтын дасгал болон кейсүүд ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтыг улам гүнзгийрүүлэн мэдэх, түүний учир шалтгаан, логик уялдааг танин мэдэхэд туслах юм. Эдгээр жишээ болон кейсийн тусламжтайгаар өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой бөгөөд сургалтын үйл явцыг сонирхолтой, бас өгөөжтэй байхад тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Мөн энэхүү гарын авлагыг төрийн бус байгууллагууд ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, төрийн байгууллагын ил тод, шударга, нээлттэй байдлыг дэмжих зорилго бүхий аливаа олон нийтийг хамарсан мэдээллийн болон кампанит ажлуудыг зохион байгуулахад суурь мэдээлэл болгон ашиглаж болно. Олон нийтэд зориулсан, энгийн хялбархан танилцуулга, сурталчилгааны сонин, мэдээллийн хуудас хэвлэн тараахад энд байгаа мэдээллийг өргөн хүрээтэй ашиглах боломж бий.

Гарын авлагад ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, түүний хэрэгжилтэд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцооны ямар механизм, аргачлал байж болох талаар багтаасан тул хуулийн хэрэгжилтийг хангах, түүнийг сайжруулахад чиглэсэн практик зөвлөмжүүдтэй эндээс танилцаж болно. Хавсралт мэдээлэл болгож ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ном зүйг оруулсан. Энэ нь илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжийг олгож байгаа хэрэг юм. Ингээд та бүхэнд хичээнгүйлэн боловсруулсан гарын авлагаа өргөн барьж байна. Та бүхний авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах замаар нийгмийн шударга ёсыг хамгаалах үйлсэд тань амжилт хүсье.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1.1. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Сэдвийн түлхүүр ойлголт:

- Ашиг сонирхлын зөрчил
- Хувийн ашиг сонирхол
- Төрийн болон нийтийн ашиг сонирхол
- Ашиг сонирхол хоорондын зөрчил
- Олон нийтийн итгэл
- Нийтийн албан дахь ашиг сонирхлын зөрчил, нийтийн албан тушаалтан, нийтийн болон хувийн ашиг сонирхол

Сэдвийн хэрэглээ:

- Мэдээлэл өгөх, сургалт явуулах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахад үзэл баримтлал, мэдээлэл болгон ашиглах
- Сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн чиглэл өгөх сургалтанд багц материал болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголтыг хөгжүүлэх тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээнд ашиглах.



Жишээ:

Нэгэн сумын дунд сургуулийн барилгыг шинээр барих тендер зарлагджээ. Уг тендерийг шалгаруулах Үнэлгээний хорооны гишүүнээр аймгийн засаг даргын тамгын газрын дарга "Х" ажилладаг. "Х"-ийн нагац дүү "Н"-ий барилгын компани тус тендерт оролцсон байна. Сонгон шалгаруулалт дуусч өөр нэг барилгын компани тендерт ялсан. Гэвч Үнэлгээний хорооны гишүүн "Х" нь "Н"-ийн компани хамгийн бага үнийн санал өгсөн байтал шалгаруулсангүй гээд гарын үсэг зурахаас татгалзжээ.

Жишээ:

Татварын байцаагч "А" ажилдаа хайнга хандсан үндэслэлээр ажлаасаа чөлөөлөгдсөн байна. "А"-г ажлаасаа чөлөөлөгдсөн даруид түүний хариуцан ажиллаж байсан уул уурхайн компани түүнд татварын байгууллагатай харилцаж ажиллах санхүүгийн ахлах менежерийн ажлыг санал болгожээ. "А" цалин мөнгөгүй, ажил орлогогүй байсан тул энэ саналыг шууд хүлээн зөвшөөрчээ.

Дээр дурьдсан хоёр жишээ бол ашиг сонирхлын зөрчлийн тухай юм. Эхний жишээ нь өөрийн нагац дүүдээ давуу байдал олгох, төрийн эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хувийн болон өөрийн хамаатны эрх ашигт үйлчилсэн байна. Харин дараагийн жишээ бол төрийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа өөрийн эрхэлж байсан ажилтай холбоотой байсан аж ахуйн нэгж байгууллагад тодорхой хугацаанд ажиллахыг хориглодог ашиг сонирхлын зөрчлийн хязгаарлалт буюу эрхэлж байсан албан тушаалаа өөрийн хувийн сонирхолд ашигласан байна. Тэгвэл ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

Хамгийн энгийн утгаар, төрийн албан хаагчийн хувийн сонирхол /заавал мөнгөн хэлбэртэй байх албагүй/, төрийн албаны үүрэг хоёр хоорондоо харшилж байгаа нөхцөл байдлын ашиг сонирхлын зөрчил гэж ойлгож болно. Хүн бүрт өөрийн гэсэн хувийн амьдрал, хувийн үзэл бодол байдаг тул үүнтэй уялдан өөрийн гэсэн хувийн сонирхол ч бас байдаг. Энэ нь төрийн албан хаагчийн хувьд ч адил




юм. Аливаа хувийн сонирхол нь эдийн болон эдийн бус, ашгийн сонирхлыг хамтад нь багтаадаг өргөн ойлголт. Иймд тухайн хүний хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь зөрчилдөж болзошгүй нөхцөлд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үздэг. Нийтийн албан хаагч гагцхүү хувийн сонирхолдоо автаж албан үүргээ биелүүлэхгүй

байх, эсвэл албан тушаалын эрх мэдлээ зүй бусаар хэрэгжүүлбэл түүний хувийн сонирхол албан үүрэгтэй нь харшилж ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг байна.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай олон янзын тодорхойлолт бий. Тухайлбал,

- Трансперенси интернейшнл байгууллагын тодорхойлсноор “ашиг сонирхлын зөрчил гэдэг нь төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно”¹ гэжээ.
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зүгээс “төрийн албан хаагчаас үүргээ гүйцэтгэхэд албаны болон хувийн сонирхол зөрчилдөх буюу төрийн албан хаагчийн хувийн сонирхол нь албаны үүргээ гүйцэтгэхэд нь харшаар нөлөөлөхийг хэлнэ”² гэжээ.

Ашиг сонирхлын зөрчлийн аль ч тодорхойлолтод дараах үндсэн гурван агуулга байгааг та харж болно.



Төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ “эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх” амлалт авдаг. Албан үүргээ ч олон нийтийн итгэл дээр үндэслэн гүйцэтгэдэг. Иймд амлалтандаа үнэнч байж, ард түмнийхээ итгэлийг алдахгүйн тулд түүний хувь хүнийх нь сонирхол нийтийн төлөө үйлсэд нь аливаа нөлөө үзүүлж болохгүй юм. Хэрэв албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн сонирхлын үүднээс хандаж олон нийтийн итгэл найдварыг хөсөрдүүлвэл энэ нь нийгмийн шударга ёсыг ганхахад хүргэнэ. Түүнчлэн, тухайн төрийн албан тушаалтан өөрийн бөгөөд гэр бүлийн гишүүн, ойрын хамаатан, төрөл садангийн хүмүүсийн эрх ашигт бага ч гэсэн үйлчилсэн, тэр нь төр, нийтийн эрх ашигт өчүүхэн төдий хохирол учруулаагүй байсан ч өндөр ёс суртахуунтай зарим улсад үүнийг ашиг сонирхлын зөрчилд тооцдог байна.

¹ Private gain from public loss: “How Thailand copes with corruption from conflict of interest” by Medhi Krongkaew, p.2.

² OECD, “Managing of Conflict of Interest: A Toolkit”, p.10.



Нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил нь авлигын сүүдэр, шалтгаан болдгийн хувьд улс орны эдийн засгийн хөгжил, ядуурлыг бууруулах, сайн засаглалыг хөгжүүлж, ардчиллыг бэхжүүлэхэд томоохон бэрхшээл учруулдаг байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтын үндсэн гол агуулга, зарчим нь “Төрийн албан тушаалтны шууд болон шууд бус хувийн болон санхүүгийн сонирхол нь үнэн зөв, бие даасан шийдвэр гаргахад нь нөлөөлөхөөр байвал тухайн асуудлаар албан байр сууриа илэрхийлж болохгүй” байх явдал юм³.

Монгол ардын зүйр цэцэн үгнээс...

*Ард олны ашиг өндөр тэнгэртэй адил
Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил*


*Уул усны ойр нь дээр
Ураг садны хол нь дээр*

Эдгээр зүйр үг, бусад адил утгатай зүйр үгийн тухай ярилцаж, ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголттой хэрхэн холбогдож байгааг анзаараарай.

Нийтийн албан дах ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт нь манай улсын хувьд харьцангуй шинэ ухагдахуун юм. Нийтийн албан дах

³ Транспэрэнси Интэрнэйшнл, Авилгалын эсрэг сурвалж бичиг, Улаанбаатар, 2003 он, 132 дахь тал.


ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах бие даасан хууль тогтоомжтой болохоос өмнө “нийтийн” гэдэг нэр томъёоны оронд “төрийн” гэсэн үг хэллэгийг ашиглаж, “төрийн алба, төрийн албан хаагч, төрийн албан дах ашиг сонирхлын зөрчил” гэх мэтээр ярьж хэвшсэн байдаг. Улмаар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-нд баталсан бөгөөд дээрх ойлголтууд нь энэ үеэс эхэлсэн шинэ нэр томъёо юм. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зорилт нь “...нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино” гэжээ. Эндээс үзэхэд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хамгийн гол хэрэгцээ бол нийтийн албаны эрх мэдлийг зөвхөн олон нийтийн төлөө л ашигладаг болгоход зориулагдаж байна. Дээр дурьдсан нэр томъёоны хуульд заасан тодорхойлолт, агуулгыг авч үзье.




НИЙТИЙН АЛБА гэдэг нь:

Нийтийн алба гэдэгт төрийн албыг бүхэлд нь хамруулан ойлгож болно. Тиймээс нийтийн алба нь нийт иргэдийн эрх ашигт нийцсэн төрөөс хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээ, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд “Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ” хэмээн тодорхойлжээ.


НИЙТИЙН АШИГ СОНИРХОЛ ГЭДЭГ НЬ:




ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ ГЭДЭГ НЬ:




АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ГЭЖ ОЙЛГОГДОХУЙЦ НӨХЦӨЛ БАЙДАЛ ГЭДЭГ НЬ



НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН ГЭДЭГ НЬ:



НИЙТИЙН АЛБАН ДАХ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ГЭДЭГ НЬ:




СУРГАЛТАД АШИГЛАЖ БОЛОХ ДАСГАЛ АЖЛУУД

Дасгал 1.

“Бэрхшээлийн мод” аргачлалын загварын дагуу “Ашиг сонирхлын зөрчил”-ийн шалтгаан, үр дагаврын талаар зураглал хийнэ үү. Доор Индонезийн Ёгикарата мужийн “Цагдаагийнхан хахууль байнга шаарддаг” сэдвээр ядуу иргэдийн хийсэн “Бэрхшээлийн мод”-ны загвар байна. Үүнийг хийхдээ дараах зүйлийг санаарай.

- Модны мөчрүүд бол “Ашиг сонирхлын зөрчил”-өөс болж ямар муу үр дагаврууд бий болж болохыг харуулна.
- Модны гол “Ашиг сонирхлын зөрчил газар авч байна” гэсэн гол бэрхшээлийг тодорхойлно.
- Модны үндэс бол “Ашиг сонирхлын зөрчил”-ийн шалтгаан болон бас уг шалтгаан юунаас гарч байгааг илэрхийлнэ.



Дасгал 2.

“Мэс засал амжилттай хийсэн эмчид талархлаа илэрхийлж мөнгө өгч болох уу” гэсэн асуултад хоёр иргэн дараах хариултыг өгчээ. Нэг нь “ойр дотны хэн нэгнийг аюулт өвчнөөс ангижруулсан алтан гартай эмчид баярласнаа илэрхийлж өгөлгүй яахав” гэж хариулжээ. Харин нөгөө иргэн нь “хийх ёстой ажил үүргээ гүйцэтгэж байгаа учраас мөнгө өгөх шаардлагагүй. Харин ч мөнгө өгснөөрөө ачит эмчээ асуудалд оруулна” гэж хариулсан байна.

Асуулт. Та дээрх хоёр хүний хэнийх нь саналыг дэмжиж байна вэ? Тайлбар өгнө үү.

Хариулт. Таны өгч буй мөнгө, эд зүйлийг тухайн эмч авах ёсгүй. Яагаад гэвэл тэр эмч албан үүргээ амжилттай гүйцэтгэх үүрэгтэй. Хэрвээ тухайн эмч үнэхээр үнэлүүлэх гавъяа байгуулсан бол төр журмынхаа дагуу уг эмчийг шагнаж урамшуулна. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дах заалтыг 2012 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр баталсан Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болгосон.

Дасгал 3.

Монгол ардын зүйр цэцэн үгэнд ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, агуулгыг харуулсан зүйр үг олон байдаг. Аль баг хамгийн олон зүйр цэцэн үг хэлэх вэ? Мөн зүйр цэцэн үгийн утга санааг ашиглан “Нийтийн албан дах ашиг сонирхлын зөрчил”-ийн үндсэн ойлголтуудыг тайлбарлаарай.

Дасгал 4.

Оролцогч бүр ашиг сонирхлын зөрчилтэй төрийн албан хаагч, ашиг сонирхлын зөрчилтэй гарсан төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар өөрт тохиолдсон болон бусдаас сонсож байсан жишээ, тохиолдлын талаар бусадтайгаа хуваалцаарай.

Дасгал 5.

Дараах кейс тус бүр дээр доод тал нь 10 минут ярилцах хугацаа гаргаж, өнгөц ярилцах, сайтар бодолцоогүй хариулт авахаас зайлсхийгээрэй.

Кейс 1.

Танай байгууллага сар бүр нэлээд хэмжээний хэвлэмэл материал нийлүүлэх гэрээ хийдэг. Өнгөрсөн хугацаанд танай байгууллагын хэвлүүлэх ажлыг гүйцэтгэж ирсэн гурван компани нь чанар сайн, үнэ өртгийн хувьд ч үр ашигтай гээд нэр хүнд сайтай. Таны эцэг саяхан хэвлэлийн компани худалдаж авчээ. Та гэрээний ажилтны хувьд бүх дунд болон жижиг тендерийн ажиллагааг гардан хийдэг үүрэгтэйн хувьд бусад компаний тендерийн саналын талаар нарийн мэдээлэл авах боломжтой. Таны эцэг өрсөлдөгчдөөс доогуур үнийн санал өгөх зорилгоор танаас мэдээлэл хүсчээ. Танай байгууллага саяхан зардал хэмнэх томоохон хөтөлбөр эхлүүлээд байгаа аж. Хэрэв эцгийнхээ саналыг хүлээж авбал танай яам хэвлэлийн зардлаас олон сая төгрөг хэмнэх боломжтой болох юм.

Асуулт. Төрийн байгууллага ихээхэн хэмжээний зардал хэмнэх нь ашиг сонирхлын зөрчилтэй харагдах уу? Хэмнэсэн явдал үүнийг зөвтгөх шалтгаан болох уу?

Хариулт. Энэ бол ашиг сонирхлын зөрчлийн жишээ. Зүй бус үйлдлээр хэмнэлт гаргах нь зөвтгөх боломжгүй. Түүнчлэн, гэр бүлийн харилцаагаар дамжуулан ашиг олж байна гэж үзнэ.

Асуулт. Ямар харагдах нь энэ тохиолдолд чухал уу? Яагаад?

Хариулт. Чухал. Олон нийтийн зүгээс төрийн байгууллага, албан тушаалтан төрийн үйл ажиллагаанд иргэдийн итгэлийг хадгалах үүрэгтэй тул чухал юм. Танил талаар асуудлыг шийдэх, албан тушаалаа урвуулан ашиглах /хувийн ашиг сонирхлын төлөө бизнесийн нууц мэдээллийг хулгай хийж өрсөлдөгчид дамжуулах зэрэг/ нь энэ тохиолдолд тухайн байгууллага хэдийгээр зардал хэмнэсэн ч авлигын ангилалд хамаарна. Иймд шударга ёс үйлчлэхгүй байна гэж харагдах бүх тохиолдлоос зайлсхийх ёстой.

Кейс 2.

Хэлтсийн даргын хувьд таныг байнгын орон тоонд ажилтан сонгон шалгаруулах комиссын даргаар томилжээ. Өргөдөл өгсөн хүмүүсийн нэг нь таны хамаатан тул та түүнийг сайн мэднэ. Сонгон шалгаруулах комиссын гишүүд харин энэ тухай мэдэхгүй. Та энэхүү харилцаа таны сонголтод нөлөөлөхгүй байхаар ажиллана гэж шийдээд комиссын гишүүдэд мэдэгдэж, танилын хувьд үнэлгээ хийх ажилд оролцохгүй боловч комиссын даргын хувьд гишүүдийн саналд үндэслэн эцсийн шийдвэрийг өөрөө гаргахаар тохирсон байна.

Асуулт. Энэ шийдвэр зөв үү?

Хариулт. Буруу. Ах дүү, хамаатан гээд гэр бүлийн харилцааны асуудал тухайн албан тушаалтанд маш чухал учир илэрхий ашиг сонирхлын зөрчилтэй харагдаж, сонгон шалгаруулах ажлын үр дүн бүхэлдээ шударга болсон эсэх асуудал тавигдана. Таны үйлдэл сонгон шалгаруулах комиссын гишүүдийн шударга ёс болон сонгогдвол хамаатныхаа шударга ёс, нэр хүндийг унагааж болох юм.

Хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой асуулт. Та яагаад комиссын гишүүний үүргээс татгалзахад бэлэн биш байна вэ?

Кейс 3.



Өөрийн ажил үүргийн дагуу албаны жолооч нь яамны бичиг хүргэх болон бусад албан ажил гүйцэтгэх үүрэгтэй. Түүний цалин бага, ажил нь байнга дуудлагаар явах төрлийн ажил бөгөөд ихэвчлэн яамнаас гадуур явдаг тул хараа хяналтгүй ажлаа гүйцэтгэх боломж олгогдсон байдаг. Жолооч яаманд олон жил ажилласан бөгөөд ямар нэг хэрэг төвөг болж байгаагүй нэгэн. Жолоочийн ажлын зохион байгуулалтын энэ байдлаа ашиглан ажлын цагаар хувийн ажлаа амжуулах боломжтой. Тухайлбал, дэлгүүрээр явах, хүүхдүүдээ сургуульд хүргэж өгөх г.м.

Асуулт. Яамны буюу төрийн өмчийн машинаар хувийн ажлаа амжуулахыг зөвшөөрч болох уу? Энэ ашиг сонирхлын зөрчил мөн үү?

Хариулт. Энэхүү ажлын зохион байгуулалт нь “боломжийн” /албан ажил хойшлогдоогүй болон байгууллагад нэмэгдэл зардал, эрсдэл учрахгүй бол/ хэмээн харагдаж болох юм. Гэхдээ энэ нь ашиг сонирхлын зөрчил бөгөөд төрийн албан хаагч төрийн өмчийн автомашиныг хувийн хэрэгцээнд хэрэглэх нь мөн асуудал үүсгэнэ.

Дасгал 6.

Дараах 4 шог зургийг сайтар ажиглаад ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой тайлбар бичнэ үү.



СЭДЭВТЭЙ ХОЛБООТОЙ ГАРЧ БОЛОХ НИЙТЛЭГ АСУУЛТ, ХАРИУЛТ

Асуулт. Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д “Ашиг сонирхлын зөрчил” гэдгийг нийтийн албан тушаалтан албаны чиг үүргээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал хэмээн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн хувьд нэг талаас олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг, нөгөө талаас хувийн сонирхол хоорондоо зөрчилдөхийг ашиг сонирхлын зөрчил хэмээн ойлгож болно.

Асуулт. Нийтийн ашиг сонирхол гэж юуг хэлж байна вэ?

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль”-д “Нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэл хэмээн тодорхойлсон. Албан тушаалтны хашиж байгаа ажил, алба бол зөвхөн нийтийн ашиг сонирхолд чиглэж байх ёстой. Өөрөөр хэлбэл, “Нийтийн ашиг сонирхол / public interest/ гэдэг нь хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрсдийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байлгах үүрэгтэй байдаг.

Асуулт. Хувийн ашиг сонирхол гэдэгт юуг хамааруулан ойлгож болох вэ?

“Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ. Хувийн ашиг сонирхол /private interest/ гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүний хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг багтаан ойлгоно гэж судлаачид тэмдэглэдэг. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуутай байдал бий болгохыг зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал, өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн

болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно гэж үздэг.

Асуулт. Нийтийн албан тушаалтан гэдэгт хэнийг хамруулах вэ?

Авлига, албан тушаалын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлийг зөвхөн төрийн албатай хамааралтай мэт явцуу ойлголтыг өөрчлөх зорилгоор хууль тогтоогчид энэхүү нэр томъёог авч хэрэглэсэн. Нийтийн албан тушаалтан гэдэгт төрийн алба болон татвар төлөгчдийн бий болгосон төсвийн хөрөнгөөр санхүүждэг бүхий л субьектийг хамааруулан ойлгох нь зүйтэй. Тиймээс төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтнууд, төрийн өмчийн болон өмчийн оролцоотой компанийн удирдлага, нийтийн эрх ашгийг илэрхийлж байгаа буюу үр ашгийг нь нийтээрээ хүртэх гадаадын техникийн туслалцаатай хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж буй удирдах албан тушаалтнуудыг нийтийн албанд хамааруулдаг байна. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтан буюу хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг нэрлэн заасан. Нийтийн албан тушаалтанд төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, хууль тогтоомжийн дагуу, эсхүл улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хамаарна.

Асуулт. “Хамаарал бүхий этгээд” гэж хэнийг хэлэх вэ?

Нийтийн алба хашиж байгаа хүний таны эцэг, эх, төрсөн ах, дүү, мөн гэр бүлийн гишүүн, таны эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, эгч, дүү тантай “Хамаарал бүхий этгээд” юм. Үүнд хамтран амьдрагч болон бусад нэгдмэл сонирхолтой этгээд ч мөн таны хувьд хамаарал бүхий этгээд болно. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 3 дугаар бүлэгт албан тушаалтан өөрийн хамаарал бүхий этгээдийнхээ хувийн ашиг сонирхолд нийцүүлэн үүсгэж болзошгүй харилцааг 12 төрлийн хориглолт, хязгаарлалт тус бүрээр зохицуулсан.

Асуулт. Тэгвэл нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт ах дүү, төрөл саднаа ойлгож болох уу?

Болохгүй. Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг нэгдмэл сонирхолтой этгээдэд хамааруулан ойлгоно.

1.2. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА АВЛИГА

Сэдвийн түлхүүр ойлголт:

- Авлига гэж юу вэ?
- Авлига ба ашиг сонирхлын зөрчлийн тодорхойлолтын төсөөтэй байдал
- Ашиг сонирхлын зөрчил хэрхэн авлига болон хувирах вэ?

Сэдвийн хэрэглээ:

- Мэдээлэл өгөх, сургалт явуулах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахад мэдээлэл болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголтыг хөгжүүлэх тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээнд ашиглах
- Сургалтын багц материал

Төрийн аливаа шийдвэрийг төрийн албан тушаалтнууд гаргахдаа нийгмийн сайн сайхны төлөө биш харин өөртөө ашигтай байдлаар гаргавал түүний хор уршгийг бид нуруундаа үүрэх болдог. Үүнээс болж бидний хүүхдүүд сурах сургуульдаа сурч чадахгүй, хүүхдүүдийн маань цэцэрлэгийн засвар хийгдэхээ больж, бид эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авах эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг. Мөн авлига болон хээл хахуулийн өртөг бидний худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнэд шингэсэн байдаг тул хямд авч болох зүйлийнхээ төлөө илүү өндөр үнэ төлөх болдог.

Жишээ:

- Бүртгэгдсэн албан тушаалын гэмт хэргүүдийн дүнгээр авлигын гэмт хэргийн улмаас 66.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд энэ хэмжээний хөрөнгөөр хөдөөгийн суманд 320 хүүхдийн суудалтай 95 дунд сургуулийг барьж байгуулах боломжтой юм.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад нийт гэрээний үнийн дүнгийн 10.45 хувь нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагддаг байна. Тухайлбал, 58.5 км хатуу хучилттай замыг 1100.0 сая төгрөгөөр барьж байгуулах байсан гэж үзвэл 115.0 сая төгрөг нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагдаж, энэ хэмжээгээр замыг барьж байгуулахад шаардлагатай материалын зардал танагдаж замын ажлын чанарт нөлөөлдөг байна.

“Авлига” гэдгийг “итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах”⁴ хэмээн тодорхойлдог. “Хувийн ашиг хонжоо” гэдгийг өргөн утгаар авч үздэг бөгөөд үүнд, өөрийн санхүүгийн болон нийгмийн сонирхлоос гадна, өөрийн ойр дотны гэр бүлийн гишүүд, улс төрийн нам, зарим тохиолдолд бие даасан байгууллага, эсвэл хүмүүнлэгийн байгууллагуудад ашиг хонжоо бий болгохыг хамааруулж үздэг⁵.

⁴ Авлигыг хэмжихүй. Хэрэглэгчийн гарын авлага. НҮБХХ, 2010 он. 22 дугаар нүүр


⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаан дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь. Гарын авлага, 2007 он, 5 дугаар нүүр

Авлигын эсрэг Монгол Улсын хуулиас.

- “Авлига” - энэ хуулийн 4.1 дэх хэсэгт заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;
- “Ашиг хонжоо” - энэ хуулийн 4.1 дэх хэсэгт заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
- “Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” - гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдлийг хийхийг;
- “Давуу байдал” - гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ.

Хэн нэгэн хүн А нь хэн нэгэн эрх мэдэлтэй хүн болох Б-д эрх мэдлээ хууль бус, шударга бусаар ашиглаж А-д эсвэл өөр нэг этгээдэд давуу тал олгохыг хүсч ямар нэг зүйл өгөхийг эсвэл өгөхөөр санал болгохыг хэлнэ. Ямар нэг зүйл өгөх буюу хийхээр санал болгоод хариуд нь ямар нэг зүйл хүсэж байгаа этгээд ямагт авлигын хэргийн буруутан байна. Хэрэв түүний саналыг нөгөө тал хүлээн авсан бол хоёр тал хоёулаа буруутай байна. Тиймээс авлига нь⁶

- нийгэмд хортой үр дагавар бүхий үзэгдэл
- төрийн алба, улс төр, бизнесийн хүрээнд эрх мэдэл худалдагдах
- албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоогоор солих
- бусдад давуу байдал олгох
- хууль бусаар албаны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах явдал юм.



⁶ Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага. 2009 он. АТГ. 3 дугаар нүүр.

Дээрх тодорхойлолтоос авлига гэдэг нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, нэг зүйлийн хоёр тал болох нь харагдаж байна. Ашиг сонирхлын зөрчил нь нэг талаас авлигын сүүдэр, шалтгаан болдог. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийг зарим судлаачид авлига гэж үзсэн байхад зарим судлаачдын судалгааны бүтээл, эх сурвалжид хараахан авлига биш харин авлига бий болох эрсдэл гэж үзсэн байна. Тухайлбал, Транспэрэнси Интэрнэйшнл байгууллагын тодорхойлсноор “авлига бол хувийн эрх ашгийн төлөө албаныхаа эрх мэдлийг урвуулан ашиглах”⁷ явдал гээд нийтийн албан тушаалтны албаны үүрэг болон хувийн сонирхол хоорондын мөргөлдөөн ч авлигад багтана гэжээ. Эндээс үүдээд авлига бол ашиг сонирхлын зөрчлийг агуулдаг гэж тодорхойлсон байна. Ашиг сонирхлын зөрчлийг авлига биш гэдэг байр суурьтай хэсэг ч ашиг сонирхлын зөрчлийг авлига болж хувирах боломжтой гэж үздэг. Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилд орж хувьдаа буюу бусдад хувийн сонирхлоо хангахад нь нийтийн албаны эрх мэдлээ урвуулан, зүй бусаар ашигласнаар ашиг сонирхлын зөрчил нь авлига болж хувирдаг. Иймээс нийтийн албан тушаалтны хувийн сонирхол албан үүрэгтэй нь зөрчилдөхөд үүнийг зөв тодорхойлж, зөв удирдаж, үр ашигтай шийдвэрлэх ёстой. Шийдвэрлэхгүй үлдээвэл ашиг сонирхлын зөрчил нь авлига, төрийн нөөцийг урвуулан ашигласан хууль бус үйлдэл болдог байна⁸.

⁷ UNDP, *Conflict of interest - Prevention, Correction, Sanction and Education. Comparative study. 2005, p.8.*

⁸ OECD, *Managing Conflict of interest in the public service, 2003, p.82.*

СУРГАЛТАД АШИГЛАЖ БОЛОХ ДАСГАЛ АЖЛЫН ЖИШЭЭ



Дасгал 1.

“Ашиг сонирхлын зөрчил” болон “авлига”-ын тодорхойлолтод байгаа адил төстэй үгийг онцлон авч оролцогчдоор тайлбарлуулна уу?

Дасгал 2.

Авлига хэрхэн ашиг сонирхлын зөрчил болон хувирдаг талаар баг тус бүр зураглал хийж, бусаддаа зориулж танилцуулга бэлтгэн олж авсан мэдлэг, мэдээллээ бататгах дасгал ажил хийгээрэй.

Дасгал 3.

Дараах кейс тус бүр дээр доод тал нь 10 минут ярилцах хугацаа гаргаж, өнгөц ярилцах, сайтар бодолцоогүй хариулт авахаас зайлсхийгээрэй.

Кейс 1.

Таны хамт ажилладаг дотны найз тань өнгөрсөн хоёр жилийн турш бэлэн мөнгө бага багаар хулгайлдаг, үүнийгээ нуух зорилгоор санхүүгийн баримтад засвар хийдэг, мөн яамны албан хэрэгцээний бичиг хэргийн хэрэгсэл материалыг хулгайлдаг байсныг та олж мэджээ. Тэр зэргэлдээ хотхонд хулгайлсан зүйлээ худалддаг байна. Яамны санхүүгийн хяналтын систем нь тун сул учир хэн ч ийм юм болж байгааг анзаараагүй байна. Таны найзын нөхөр өвчтэй, дээр нь гэр бүлээ авч явах гээд олон дарамттай бөгөөд найзын тань төрийн албан хаагчийн бага цалин нь тохилог амьжиргааг хангаж чаддаггүй байна.

Асуулт. Энд ашиг сонирхлын зөрчил байна уу. Энэ авлигын хэрэг мөн үү?

Хариулт. Байна. Та хулгайн хэргийг мэдүүлэх үүргээ гүйцэтгэх болон энэ төвөгтэй асуудалд хутгалдахгүй чимээгүйхэн амьдрах гэсэн ашиг сонирхолтой тань зөрчилдөж байна. Таны найз хулгай хийхгүй байх үүрэг болон хувийн ашиг хоёрын хоорондын зөрчилтэй байна. Энд зөвхөн түүний гэр бүл дан ганц цалингаар тохилог амьжиргаагаа хангаж чадахгүй гэдэг нь үүнийг зөвтгөх шалгаан биш. Тэр ажил олгогчоос хулгай хийхдээ албан тушаалаа урвуулан ашигласан тул энэ хэрэг ашиг сонирхлын зөрчлийн хэргээс хальж авлигын хэргийн ангилалд буюу албан тушаалаа урвуулан ашигласан хэрэгт хамаарахаар байна.

Кейс 2.

Танай байгууллага хотын хоолны газар болон ресторануудад лиценз олгох ажлыг хариуцдаг. Таны ажил үүргийн хуваарьт тэдгээр лиценз авах өргөдлийг шийдвэрлэх ажил ордог байна. Нэг өдөр олонд нэртэй нэгэн хоолны газрын дарга ноён “А” таны ажил дээр ирээд маргааш нь хугацаа дуусах гэж байгаа лицензийн хугацааг яаралтай сунгаж өгөхийг хүсчээ. Тэр яаралтай ажлаар гадагш явсан байсан тул сунгах хугацаа тулсныг анзаарсангүй гэнэ. Шат дамжлага зэргээр явсаар байгаад лицензийн хугацаа сунгах шийдвэр гарахад нэг 7 хоног шаардагддаг аж. Танай байгууллага, лицензгүй ажиллавал хатуу торгох бодлого хэрэгжүүлдэг учир хэрэв ноён “А” лицензгүй ажиллаж баригдвал лиценз болон зах зээл дэх байр сууриа алдах юм. Нэг өдрийн дотор лицензийг шинэчилж өгвөл талархал болгон танд болон танай гэр бүлд бүтэн сар үнэгүй хоолоор үйлчлэхийг танд санал болгожээ. Энэ нь таны 7 хоногийн цалинтай тэнцэх тул танд их ашигтай санал юм. Энэ бэлгээс татгалзвал ноён “А” их гомдох гэнэ. Танай байгууллага авлигатай тэмцэх хатуу журамтай боловч журмаар хориглосон бэлэгт хоол ордоггүй гэж боддог. Хэрэв та энэ саналыг хүлээж авбал өмнө нь орж ирсэн хэдэн өргөдөл шийдвэрлэх асуудал 3 хоногоор хойшилно.

Асуулт. Энд ашиг сонирхлын зөрчил байна уу?

Хариулт. Тухайн тохиолдолд санал болгосон үнэ бүхий бэлэг ашиг сонирхлын зөрчил бий болгоод зогсохгүй хээл хахууль авсан гэмт хэргийн шинжтэй байна. Цаг хугацаандаа өргөдлөө өгсөн хүмүүсийн лиценз олгох хугацааг зохих шалтгаангүй хойшлуулах нь мөн асуудал үүсгэнэ. Хэрэв бэлгийг хүлээж авахгүй бол их гомдоно гэдэг нь огт ач холбогдолгүй, зөвтгөх боломжгүй нөхцөл юм.

Кейс 3.

Та өөр хэлтсийн хоёр ажилтны яриаг (00 өрөөнд) өөрийн эрхгүй сонсож, түүнд нэг ажилтан нь инээж ирээд л яаж даргаараа албан тушаал дэвших шийдвэр гаргуулсан тухайгаа ярьжээ. Тэр ажилтны ярьж байгаагаар, даргынхаа иргэдээс хахууль авдаг тухай мэдүүлэхгүй (уг нь тэр дарга нэлээд олон төрлийн гэмт хэрэгт шалгагдах ёстой хүн аж) гэж амлаж байгаад тушаал ахисан гэнэ.

Удирдах ажилтны хувьд та засгийн газар хээл хахуулийн гэмт хэргийг эрүүгийн ноцтой гэмт хэргийн ангилалд оруулах гэж байгааг мэднэ. Танай өөрийн яамны нэвтрүүлсэн ажиллагсдын авлигатай тэмцэх шинэ чангатгасан бодлогод удирдах ажилтнууд бусдад үлгэр жишээ болохыг шаардсан заалтууд орсон билээ. Мөн тухайн удирдах ажилтан танай газрын ажиллагсад болон дээд удирдлагын хүрээнд нэр хүндтэй гэдгийг ч мэднэ.

Асуулт. Энд ямар зөрчлүүд байна вэ?

Хариулт. Энд өнгөц харахад ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал байж болох юм. Гэвч энд дурдагдсан нөхцөл байдал нь албан тушаалтан Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлд заасан авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газар нэн даруй мэдээлээгүй зөрчил, түүнчлэн, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг нуун дарагдуулсан, бусдыг далайлган сүрдүүлсэн гэмт хэргийн шинжтэй байж болохоор байна. Үүний зэрэгцээ таны сонссон яриа худал бол удирдлагын нэр хүнд ноцтой эрсдэлд байна гэсэн үг бөгөөд ажилд авдаг, албан тушаал дэвшдэг тогтолцоонд итгэх итгэлд сэв сууна. Учир нь ийм яриа хурдан тархдаг бөгөөд засч залруулахад хүндрэлтэй, зарим тохиолдолд боломжгүй байдаг. Та удирдах албан тушаалтны хувьд энэ яриаг хянан шалгахад хариуцлагатай хандах нь зүйтэй юм.

1.3. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ, ХОРИГЛОЛТ БОЛОН ХЯЗГААРЛАЛТ

Сэдвийн түлхүүр ойлголт:

- Ашиг сонирхлын зөрчлийн төрөл, хэлбэрүүд
- Нийтийн албан тушаалтнаас албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт

Сэдвийн хэрэглээ:

- Мэдээлэл өгөх, сургалт явуулах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахад мэдээлэл болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголтыг хөгжүүлэх тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээнд ашиглах
- Хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ, мониторинг хийхэд мэдээлэл болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой судалгаа авахад зориулсан асуулга боловсруулахад ашиглах.



Ашиг сонирхлын зөрчлийн дараах нийтлэг төрлүүд байдаг бөгөөд улс орон бүр өөрсдийн хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулдаг байна. Үүнд,

- Төрийн албан хаагч ямар нэг байдлаар хувийн сонирхлын зөрчилд орж болзошгүй шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх
- Тодорхой асуудлаар шийдвэр гаргахад эрх мэдэл, ажил, албан тушаалын байдал, танил талын хүрээгээ ашиглан шууд буюу шууд бусаар нөлөөлөх
- Ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө ивээл үзүүлж, давуу эрх олгох
- Төрийн албан хаагч нь ажил үүрэгт нь нөлөөлөхүйц болон хяналт тавих үүрэгт нь багтдаг өөр бусад ажил, албан тушаал эрхлэх, хавсран гүйцэтгэх

- Аливаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон бусад хуулийн этгээдийн удирдах байгууллагын гишүүн байх
- Шууд удирдлага буюу хяналт тавьдаг албан тушаалтан нь гэр бүлийн гишүүн, садан төрлийн холбоотой байх
- Төрийн албанаас гарснаас хойш тодорхой хугацаанд хяналтын үүрэг функцын хувьд холбоотой байсан байгууллагад ажиллах
- Төрийн албан тушаал эрхэлж байх явцдаа олж авсан мэдээллээ ашиглах буюу ашиглахыг зөвшөөрөх.

Ашиг сонирхлын зөрчил нь хэд хэдэн янзаар илэрч болдог⁹. Тухайлбал:

Нэг. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд:

- Хувийн хэвшлийн байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа өөрийн танил байгууллагыг дур мэдэн сонгох, эсвэл сонгон шалгаруулалт явуулахгүй байх
- Лиценз, зөвшөөрлийг хууль тогтоомж зөрчиж танил талдаа олгох
- Төрийн албанаас гарсныхаа дараа ажил үүргийнхээ хувьд холбоотой байсан хувийн хэвшлийн байгууллагад ажилд орох.

Хоёр. Төрийн албан тушаал эрхлэхэд:

- Өөрт ямар нэг хамаарал бүхий компани нь тендерт өрсөлдөж буй нөхцөлд тендерийн комиссын сонгон шалгаруулах үйл явц, шийдвэр гаргалтанд оролцох
- Тендерийн комиссын гишүүн болох доод албан тушаалтандаа захиа, даалгавар өгөх, элдэв нөхцөл болзол тавих
- Танил бус боловч шударгаар сонгогдсон байгууллагын ажлыг хойш тавих, ялгаварлан гадуурхах.

Гурав. Албаны мэдээ, мэдээллийг ашиглахад:

- Тендерийн сонгон шалгаруулалтын нөхцөл болзлыг нийтэд зарлаагүй үед танил байгууллагадаа урьдчилан мэдээлэх
- Нийтэд нээлттэй байх ёстой мэдээ, мэдээллийг нуун дарагдуулах
- Албаны мэдээ, мэдээллийг ашиглан танил байгууллагадаа зөвлөгөө өгөх.

Дөрөв. Бусдын өмнө үүрэг амлалт авах аливаа нөхцөл байдлыг бүрдүүлэх:

- Албан үүргээ гүйцэтгэхтэй шууд буюу шууд бус холбоотойгоор бэлэг буюу бусдын үйлчилгээг шууд буюу шууд бусаар хүлээн авах
- Өөрийн хянан шалгадаг үйлчилгээний байгууллагаас үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй аливаа үйлчилгээ авах.

Тав. Хөрөнгө оруулалт хийхэд:

- Өөрийн хянан шалгадаг болон төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хөрөнгө оруулалт хийх

⁹ АТГ, Монгол улс дахь сонирхлын зөрчлийн байдалд хийсэн судалгаа, Улаанбаатар, 2008 он, 17 дахь тал

- Олон нийтэд зарлагдаагүй мэдээллийг ашиглан давуу байдлыг олж авах үүднээс хөрөнгө оруулалт хийх.

Зургаа. Бусад ажил хавсран гүйцэтгэхэд:

- Албан үүргийн хувьд холбоотой байгууллагын удирдлагад буюу төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах
- Албаны мэдээ, мэдээллийг ашиглан бусдад зөвлөгөө өгөх компани ажиллуулах
- Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа албан үүргийн хувьд холбоо харилцаатай байсан компанид ажилд орох зэрэг юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтанд албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах 12 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хуулиар тогтоож өгсөн бөгөөд нийтийн албан тушаалтнууд энэ хориглолтыг дагаж мөрдсөнөөр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө ашиг сонирхлын зөрчилд орохоос хамгаалах боломжтой. Харин иргэд, төрийн бус байгууллагуудын хувьд эдгээр хориглолт, хязгаарлалтыг танин мэдсэнээр хуулийн хэрэгжилтийг хангахад оролцох, үнэлгээ мониторинг хийх, өөрсдийн эрхээ хамгаалах, нийтийн албыг хувийн сонирхолд урвуулан ашиглахаас сэргийлэх боломжтой болох юм. Тиймээс нийтийн албан тушаалтанд хуулиар тавигдсан ашиг сонирхлын зөрчлийн хориглолт, хязгаарлалтыг нэг бүрчлэн хуулийн заалт болон жишээний хамт авч үзье.



1. Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт

10.1. Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг албан хаагч нэгэн үйлчилгээний байгууллагад хяналт шалгалт хийхдээ олж авсан тухайн байгууллагын мэдээллийг түүнтэй ижил төрлийн үйлчилгээ эрхэлдэг найздаа өгөхийг хориглоно.



2. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт


11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.2. Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Мэргэжлийн хяналтын байцаагч Х нь өөрийн хадам ээж Н-ийн



эрхлэн ажиллуулдаг оёдлын үйлдвэрт шалгалт явуулах боломжгүй юм.

- Одоо шүүгчээр ажиллаж байгаа А нь Б компанид хэлтсийн даргаар ажиллаж байсан. А нь 2 жилийн хугацаанд Б компанитай холбоотой маргаанд шүүгчээр оролцохоос татгалзах үүрэгтэй.


3. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох

12.1. Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:


- Засаг дарга А нь өөрийн арван жилийн ангийн найз Б-ийн гуйлтаар бичиг баримтын бүрдүүлэлт дутуу байхад газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгохын төлөө доод албан тушаалтандаа шахалт үзүүлэх, нөлөөлөхийг хориглоно.



4. Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт

13.1. Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас



Жишээ нь:

- Мэргэжлийн хяналтын эрүүл ахуйн байцаагч М нь өөрийн хувьцаа эзэмшдэг, байгалийн гаралтай хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг В компанийн бүтээгдэхүүнийг сурталчлах нь хориотой.

5. Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт

14.1. Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно.

14.2. Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно.

14.3. Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:

14.3.1. өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;

14.3.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

14.3.3. албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Албан тушаалтан Ө өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний компанитай албаныхаа нэрийн өмнөөс ямар нэгэн гэрээ хэлэлцээр хийж, нийтийн албыг төлөөлөн оролцохыг хориглоно.



6. Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт

15.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.

15.2. Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас



Жишээ нь:

- Нийтийн албан тушаалтан Д өөрийн албаны үүргээ биелүүлсний төлөө тухайлбал, лицензээ зохих журмын дагуу сунгах гарын үсэг зурахдаа хууль тогтоомжид тусгаагүй нэмэлт төлбөр хураамж авахыг хориглоно.


7. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт

16.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.

16.4. Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас



Жишээ нь:

- Нийтийн албан тушаалтан Ц-ийн хуриманд ах, дүү нар нь цахилгаан барааны иж бүрдэл авч өгсөн нь хууль зөрчсөн үйлдэл биш юм. Харин албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой аливаа бэлэг нь хүлээн авах боломжгүй бэлэг юм.

8. Хандив авахтай холбогдсон хязгаарлалт


17.1. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

17.2. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй

гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

17.4. Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас



Жишээ нь:

- Төрийн байгууллагын удирдлага өөрийн албан хаагч нарт зориулсан гарын авлагыг олон улсын байгууллагын санхүүжилтээр хэвлүүлсэн нь хууль зөрчсөн үйлдэл болохгүй. Харин сумын засаг дарга ойн арга хэмжээ зохион байгуулахад уул уурхайн компаниас аливаа хандив туслалцаа авах, хүсэх нь хориотой юм.

9. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт

18.1. Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

18.6. Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй,



эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Нийтийн албан тушаалтан Ж олон улсын байгууллагын төслөөр хэрэгжиж буй гарын авлага боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах, албан тушаалтан О төрийн байгууллагын захиалгаар судалгааны ажил гүйцэтгэх нь хориотой бус, харин тухайн нийтийн албан тушаалтны хувьд хуулиар хориглосон, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүй, хуулиар тогтоосон хэмжээнээс илүү орлого олдог зөвшөөрөгдсөнөөс бусад аж ахуйн үйл ажиллагааг давхар эрхлэх нь хориотой болно.

10. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт

20.1. Албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

20.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.



20.5. Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Татварын албанд бүртгэлтэй ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа жилийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болох бөгөөд эдгээрээс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагааг гардан эрхлэх, удирдах бүтцэд ажиллах нь хориотой.

11. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт

21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1. урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2. урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;

21.1.3. урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

21.3. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Монгол банкны хянан шалгагч А нь 2012 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон. Үүний дараа Х банкинд газрын захирлын албан тушаалын санал ирсэн байна. А нь 2014 оноос өмнө буюу 2 жилийн хугацаанд уг ажлын саналыг хүлээн авах боломжгүй юм.
- Ч татварын байцаагч болохоос өмнө уул уурхайн П компанид ажиллаж байсан бол нийтийн албан тушаал эрхлэх хугацаандаа уг компанитай холбоотой аливаа шийдвэр гаргахад оролцох ёсгүй.



12. Бусад орлогын хязгаарлалт

22.1. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

22.3. Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

22.3.1. шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;

22.3.2. холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

22.3.3. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;

22.3.4. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Жишээ нь:

- Албан тушаалтан өөрийн албан тушаалын цалин хөлснөөс гадна хуулиар хориглоогүй ажил, аж ахуйн үйл ажиллагаанаас орлого олж болох бөгөөд харин төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид ажиллаж байсан этгээдэд хуулиар нарийн тодорхой хязгаарлалтууд тавигдсан байна.



Дээрх зохицуулалтуудаас үзэхэд зарим зохицуулалтыг хориглодог, харин заримыг нь хязгаарладаг болохыг та ажигласан байх.

СУРГАЛТАД АШИГЛАЖ БОЛОХ ДАСГАЛ АЖЛУУД



Дасгал 1.

Оролцогчдыг 12 багт хуваан ашиг сонирхлын зөрчлийн хориглолт тус бүрээр тодорхой зохицуулалт, холбогдох кейс, зохицуулсны ач холбогдол, хориглолтыг зөрчсөн тохиолдолд үүсэх хор аюул, муу тал зэргийг багтаасан жижиг танилцуулга бэлтгэн бусаддаа танилцуулах боломжтой.

Дасгал 2.

Ашиг сонирхлын зөрчлийн төрлүүдийг хориглосон тодорхой хязгаарлалт тус бүрийг харуулсан тохиолдлыг сонгон авч дүрд тоглох аргаар мэдлэг, мэдээллээ бататгах боломжтой. Үүндээ гарын авлагад багтсан байгаа олон жишээ, тохиолдлоос сонгон авч ашиглах боломжтой.

Дасгал 3.

Доор байгаа кейсүүд бол бодит жишээ юм. Тиймээс кейс тус бүр дээр доод тал нь 10 минут ярилцах хугацаа гаргаж, өнгөц ярилцах, сайтар бодолцоогүй хариулт авахаас зайлсхийгээрэй. Эсвэл оролцогчдыг багт хуваан кейс тус бүр дээр ажиллуулах боломжтой.

1. Нийслэлийн-р сургууль нь сургуулийн жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахад төгсөгчдөөсөө хандив өг гээд нэхээд байх юм. Энэ зөв үү.
2. Нийгмийн даатгалын орон тооны бус байцаагч ажиллуулах тухай журам баталж мөрдүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэл, дүүрэг, сумын нийгмийн даатгалын газар, хэлтэст дарга, нягтлан бодогч, тасгийн дарга, нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байгаад

өндөр насны тэтгэвэрт гарсан иргэдийг тэтгэвэрт гарснаас хойш 2 жил болоогүй байхад нь гэрээ байгуулан орон тооны бус зөвлөхөөр ажиллуулж болох уу?

3. Дүүргийн нэгэн сургуулийн төгсөгч хөдөлмөрийн аюулгүй байдлын улмаас нас барсанд сургуулийн багш нар ар гэрт нь туслах зорилгоор сургуулийн сурагч хүүхэд бүрээс 2000 төгрөг өгөхийг шаардсан байна. Энэ нь хуульд нийцэх үү.
4. улсад амьдарч буй Монгол улсын иргэн нь Монгол улсын үндэсний E серийн гадаад паспортоо сунгуулахаар улсад суугаа Монгол улсын элчин сайдын яаманд холбогдох төлбөрийг төлөөд Монгол улс руу явуулахад Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтан 80.000 төгрөгөөр торгууль гэж үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр гаргуулан авч болох уу?
5. Аймгийн татварын хэлтэст ажиллаж байгаад албан үүргээсээ чөлөөлөгдсөн хүн шинээр аж ахуйн нэгж, үйлчилгээний газар байгуулан ажиллах мөн байгууллагуудад татварын зөвлөхөөр ажиллаж болох уу?
6. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт нь төрийн бус байгууллага бөгөөд түүний харъяа орон нутгийн салбарын даргыг тухайн аймгийн мэргэшсэн нягтлан бодогч нарын хурлаар сонгодог. Одоогоор орон нутгийн салбарын даргаар ихэвчлэн тухайн аймгийн засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, бүртгэлийн мэргэжилтэн зэрэг төрийн албан хаагчид сонгогдон ажиллаж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ямар заалтыг зөрчиж байгаа талаар тодорхой тайлбар өгч туслана уу.
7. Буянт-Ухаа спорт ордонд “Женко” клубын дэргэдэх чөлөөт бөхийн, “Аттила” клубын дэргэдэх дугуйн секц түрээсийн журмаар ажилладаг. Дээрх төрийн бус байгууллагууд нь биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд юм. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчиж байгаа эсэх талаар зөвлөгөө өгнө үү.
8. Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан “тэтгэвэр, тэтгэмж олгох” үндсэн чиг үүргээ арилжааны банкуудаар дамжуулан тэдгээртэй байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу хэрэгжүүлдэг бөгөөд зарим орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсийн байранд иргэдэд үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор арилжааны банк байрлан ажиллаж байна. Гэтэл Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль батлагдан гарснаар тус арилжааны банкуудыг байрнаасаа гаргах тухай албан бичиг ирүүлсэн байна. Энэхүү асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэх вэ?

СЭДЭВТЭЙ ХОЛБООТОЙ ГАРЧ БОЛОХ НИЙТЛЭГ АСУУЛТ, ХАРИУЛТ

Асуулт. Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх удирдамж батлагдсаны дараа энэ талаар хамрагдах аж ахуйн нэгжид ажилладаг найздаа ярих нь хууль зөрчсөн үйлдэлд тооцогдох уу?

Хариулт. Тооцогдох үндэслэлтэй. Учир нь та нийтэд мэдэгдээгүй байгаа тухайн мэдээллийг бүрэн эрхийнхээ дагуу олж авсан бол ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүйн тулд хэнд ч энэ талаар ярих ёсгүй. Хяналт, шалгалтын ажлын удирдамжид хугацаа, хамрагдах аж ахуйн нэгж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн зэрэг мэдээллийг багтаасан байдаг бөгөөд тэр бүх мэдээллийг хууль бусаар задруулсан гэж үзнэ.

Асуулт. Албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолтын талаар тодруулна уу?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу албан тушаалтанд албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Тодруулбал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” хэмээн заасан. Тиймээс албан тушаалтан урьд нь ажиллаж байсан байгууллагатай 2 жилийн хугацаанд нийтийн албыг төлөөлж хамтран ажиллах гэрээ байгуулахыг хориглосон.

Асуулт. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох гэж юу хэлж байна вэ?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд

өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасан. Энэ заалтын дагуу албан тушаалтан бусад этгээдийг шийдвэр гаргахад нь хөндлөнгөөс нөлөөлөх нь хууль бус үйлдэл болно. Тухайлбал, дүүргийн прокурор хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдийнхээ гүйцэтгэх захирлыг согтуугаар машин барьж замын хөдөлгөөнд оролцсон асуудлыг шалгаж буй замын цагдаагийн байцаагч руу ярьж хөнгөн шийтгэл оноохыг шаардах нь өөрийн албан тушаалын байдлыг ашиглан нөлөөлж буй хууль бус үйлдэл болно.

Асуулт. Жолооч нарт зориулсан замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж зорчих тухай сурталчилгаанд гаалийн байцаагч оролцож болох уу?

Хариулт. Болохгүй. Гаалийн байцаагч нь гаалийн мэдүүлэг үнэн зөв бөглөх гэх мэт өөрийнхөө албан үүрэгт хамаарах асуудал бүхий зар сурталчилгаанд оролцож болох юм. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно” гэж заасан. Харин ийм төрлийн сурталчилгаанд замын цагдаагийн албан хаагч нар болон зам тээвэр болон замын хөдөлгөөний дүрмийг сахиулахтай холбоотой албан үүрэг гүйцэтгэдэг нийтийн албан тушаалтан оролцож болох юм.

Асуулт. Нэгэн яам худалдан авах ажиллагаа хариуцсан нэг л ажилтантай бөгөөд тухайн ажилтны гэрээ байгуулах компани түүний төрсөн эгчийнх байвал яах вэ?

Хариулт. Тухайн ажилтны нийтийн албыг төлөөлөн гэрээ байгуулах тал нь хувийн ашиг сонирхлоор холбоотой этгээд байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын өмнө нийтийн албыг төлөөлөхийг хориглосон байдаг

Асуулт. Албан тушаалтан бэлэг авч болох уу?

Хариулт. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд болон шууд бусаар авахыг хориглоно. Гэхдээ албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг, албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг энэ хязгаарлалтад хамаарахгүй. Албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлгийг авсан

бол “Засгийн газрын дипломат журмаар авсан бэлэг авах, тайлагнах, зарцуулах үйл ажиллагааг зохицуулсан журам”-ыг дагаж мөрдөнө. Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш 2 жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

Асуулт. Хандив авахтай холбогдсон харилцааг хуулиар хэрхэн зохицуулсан бэ?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцаа авах, хүсэхийг хориглоно” хэмээн заасан. Гэхдээ авахыг зөвшөөрсөн хандив бий. Гол нь албан тушаалтны албан үүрэгтэй нь холбогдолгүй, тухайн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй гуравдагч этгээдээс өгсөн хандив байх ёстой. Албан тушаалтан албан хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг хандив, бусад санхүүгийн туслалцааг авч болно. Гэхдээ хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх ёстой. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагад энэ заалт мөн адил хамаарна.

Асуулт. Нийтийн албан тушаалтан хуулиар зөвшөөрсөн өөр ямар ажил, албан тушаал эрхэлж болох вэ?

Хариулт. Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албан тушаалтнаас бусад албан тушаалтан хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил, багшлах, эрдэм шинжилгээ болон бүтээлч ажил, ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг гүйцэтгэж болно. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан нь салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Харин зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх

гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “Татварын албанд ажил үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийг давхар эрхэлж болно” гэж заасан.

Асуулт. Албан тушаалтан аж ахуйн үйл ажиллагааг гардан эрхэлж болох уу?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18.6-д “Татварын албанд ажил үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногоо, тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийг давхар эрхэлж болно” гэж заасан. Албан тушаалтан эдгээрээс бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно. Мөн нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд албан үүрэгтэй холбоотой байсан аж ахуйн нэгж байгууллагад ажиллахыг хориглодог байна.

Асуулт. Албан тушаалтанд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа ямар хязгаарлалт тавьдаг вэ?

Нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах, урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрөл хүсэх, урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх үед ашиг сонирхлын зөрчил үүсч болох үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Гэхдээ 2 жилийн хугацаа харгалзахгүй дараах үйл ажиллагаагаар холбогдож болох хязгаарлалтыг тогтоож өгсөн байна. Албан тушаалаас чөлөөлөгдөхөөс өмнө байгуулсан болон сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу зохион байгуулагдсан, жилд олох орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх орлогоос хэтрэхгүй бага үнийн дүнтэй гэрээ, контракт байгуулж болно.

ТАРААХ МАТЕРИАЛ

Нийтийн албан тушаалтанд Ашиг сонирхлын зөрчлийн хуулиар хориглосон хориглолт, хязгаарлалтуудыг дараах байдлаар хялбаршуулан сургалтад оролцогчдод таниулахад, түүнчлэн сургалтын үед болон сурталчилгааны материал болгон ашиглах боломжтой.

1



Албаны бүрэн эрхийн хүрээнд олж авсан мэдээллээ хувьдаа ашиглах.

2



Албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэйгээ хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, түүнд оролцох.

3



Өөрийн болон өөртэйгээ хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргахад нөлөөлөх.

4



Албан үүрэгтээ хамаарахгүй тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалаа ашиглах, байгууллага, аж ахуй нэгжийг төлөөлөх.

5



Албан үүрэг болон өөртэйгээ шууд, шууд бусаар холбогдох байгууллага, аж ахуй нэгжийг төлөөлөх.

6



Албан үүргээ гүйцэтгэсний төлөө шууд болон шууд бус хэлбэрээр бэлэг авах. Дипломат журмаар авсан бэлгийг тайлагнахгүй байх.

7



Албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа хэлбэрээр төлбөр, нэмэлт хураамж авах.

8



Нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс хандив авах, хүсэлт гаргах. Дээрх тохиолдолд өөрийн удирдлагаас зөвшөөрөл авах хэрэгтэй.

9



Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд давхар ажил эрхлэх.

10



Албан тушаалтан хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллах.

11



Нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох үйл ажиллагаанд оролцох.

12



Нийтийн албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авсан цалин хөлснөөс гадна хуулиар хориглоогүй орлого олж болно.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

2.1. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Сэдвийн түлхүүр ойлголт:

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замууд
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх үүрэг
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтны хүлээх үүрэг
- Нийтийн албаны ёс зүйн дүрэм
- Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо

Сэдвийн хэрэглээ:

- Мэдээлэл өгөх, сургалт явуулах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахад мэдээлэл болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ, мониторинг хийхэд мэдээлэл болгон ашиглах
- Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой судалгаа авахад зориулсан асуулга боловсруулахад ашиглах.



Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахын хамгийн чухал зорилт бол төрийн байгууллагын бодлого, шийдвэр гарах үйл явцын шударга байдлыг хамгаалах, мөн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хянах, зохицуулах замаар төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах явдал юм. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дараах арга замыг тодорхойлж өгсөн байна. Үүнд,

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоох, мөрдүүлэх
2. Нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах
3. Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх
4. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, энэ тохиолдолд бичгээр зөвлөмж өгөх
5. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд төрийн байгууллагын удирдлага өөрийн удирдлагад ажиллаж байгаа албан тушаалтанг давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.

Нэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоох, мөрдүүлэх

Ёс зүйн асуудал нь нэг талаас хувь хүний зан байдлын, нөгөө талаас эрх зүйн ойлголт учраас ёс зүйн хэм хэмжээ нь өргөн агуулгатай. Үүн дотор ашиг сонирхлын зөрчил багтаж, ёс зүйн нэг шаардлага нь болдог. Засгийн газраас баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ээр төрийн захиргааны байгууллага бүр тус дүрмийг дагаж мөрдүүлэн байнгын хяналт хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон байна. Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлахдаа тус дүрмийг жишиг болгон авч болохыг мөн хүлээн зөвшөөрсөн. Тус дүрмийн 4.1.1 дэх хэсэгт төрийн албан хаагч нь “хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах” явдлыг эрхэмлэн дээдлэхээр заажээ. Дүрмийн 5 дугаар зүйлд зааснаар “өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх”, “өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах”-аар, мөн зүйлээр дараах ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрийг хориглосон байна.

- Үндсэн ажлаас гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх

- Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх
- Танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэнэ гэжээ.

Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ыг батлан мөрдүүлж байна. Дүрмийн зорилго нь ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагчийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэгддэг. Тус журмаар байгууллага бүр ажилтны тооноос хамааран өөрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган тогтоох, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус Ёс зүйн хороотой байхаар заажээ. Ёс зүйн хороо нь ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах үүрэгтэй байна.

Ихэнх төрийн байгууллагууд өөрийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж байгаа бөгөөд ёс зүйн дүрмийн нэг бүлэг заалт нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хэм хэмжээ байдаг.

Хоёр. Нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах



Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгэн томоохон, үр дүнтэй арга хэмжээ бол хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах явдал юм. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийтийн алба хашиж байгаа болон тэдгээр албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос баталсан маягтын дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө, үнэн зөв гаргах үүрэгтэй байдаг. 2012 оны байдлаар 45.096 нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг гаргах ёстойгоос 45.000 иргэн мэдүүлгээ гаргасан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас.

- 25.1. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.
- 25.2. Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

Дээрх зохицуулалтаас харахад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг иргэд болон олон нийтэд нээлттэй бөгөөд тодорхой байгууллага, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын байдалд хяналт тавих боломж ийнхүү хуулиар олгогдсон байна. Иймд иргэд болон төрийн бус байгууллага дараах байгууллагад хандан тодорхой албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үзэж танилцах, холбогдох мэдээлэл авах өргөн боломж байна. Үүнд,

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Авлигатай тэмцэх газарт
- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд
- Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн талаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд

- Бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд хандана.

Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 196 тоот тушаалаар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл өгөх журам”-ыг баталсан байна. Тус журмаар албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн аль хэсэг олон нийтэд нээлттэй байх вэ гэдгийг тогтоож олон нийтэд ямар арга замаар нээлттэй байлгахыг журамлан тогтоожээ. Төрийн өндөр албан тушаалтнуудын мэдүүлгийг Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтэлдэг бөгөөд Авлигатай тэмцэх газрын [www.хасхот.iaас.mn](http://www.hасхот.iaас.mn) цахим хуудасны вэбсайтын “Хөрөнгө, орлого, сонирхлын зөрчлийн мэдүүлэг” гэсэн хэсгээс танилцаж болно.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар дээр дурьдсан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл авах хүсэлтээ доор байгаа загвар, маягыг ашиглан гаргана.



Байгууллагын удирдлага тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор мэдээлэлтэй танилцах, эсвэл гаргаж өгөх зөвшөөрөл олгох бөгөөд уг зөвшөөрлийн дагуу эрх бүхий албан тушаалтан нэн даруй холбогдох мэдээллийг өгдөг байна.

МЭДЭЭЛЭЛ АВАХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Зөвхөн эрх бүхий ажилтан бөглөнө.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг:.....

Байгууллагын нэр:.....

Хүлээн авсан огноо:.....

Хүлээн авсан хүний нэр, албан тушаал:

А. Хүсэлт гаргах шалтгаан, үндэслэл	
В. Хүсэлт гаргагч	
1. Ургийн овог: 2. Эцгийн нэр: 3. Нэр:	
4. Төрсөн огноо:	5. Регистрийн дугаар:
6. Иргэний үнэмлэхийн дугаар:	7. Хүйс: эрэгтэй / эмэгтэй
8. Оршин суугаа хаяг:	
9. Гар утас:	10. Гэрийн утас:
11. Ажлын утас: дотуур:	12. И-Мэйл:
13. Шуудангийн хайрцаг:	14. Факс:
15. Ажлын газар, албан тушаал	
Г. Сонирхож буй мэдээллийн төрөл	
Албан тушаалтны нэр, албан тушаал	Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын аль нь болох
Иргэн овогтой би Албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаарх мэдээллийг ашиглахдаа Үндсэн хууль, бусад хуулийг зөрчихгүй байж, хувь хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэг хүлээж байна. Энэхүү үүргээ биелүүлээгүй бол хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.	
Хүсэлт гаргагчийн гарын үсэг: _____ Огноо: _____/_____/_____	
᠎ Зөвхөн зөвшөөрөл өгөх эрх бүхий албан тушаалтан бөглөнө.	
1. Зөвшөөрсөн: /Овог нэр/	
2. Албан тушаал:	
3. Гарын үсэг:	
4. Огноо:	
3. Хүсэлтэнд зөвшөөрөл өгөхөөс татгалзах	
Хүсэлт тодорхой бус	Бусад

Дээр дурьдсаны дагуу олж авсан болон танилцсан мэдээллээ иргэн, байгууллага түгээх, ашиглахдаа Үндсэн хууль, бусад хуулийг зөрчихгүй байх, хувь хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд хуульд заасны дагуу хариуцлага хүлээдэг байна.



Иргэд болон төрийн бус байгууллагын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оролцох бас нэгэн оролцоо бол өргөдөл, гомдол гаргах эрх юм. Энэхүү эрх Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтаар олгогдсон эрх юм.

Санамж.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль нь Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжтой нягт уялдаа холбоотой хууль гэдгийг санаарай.

Иргэд өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, төрийн байгууллагын ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэрийг засуулах, хүнд суртлыг арилгах, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хөнгөн шуурхай болгох, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэхэд томоохон хувь нэмэр оруулдаг.


Мэдээлэл.

Зөвхөн Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс 2010 онд 149, 2011 онд 179, 2012 онд 161, 2012 онд 161 өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн. Зөрчлийн хэлбэрээр нь авч үзвэл иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээтэй холбоотой хүнд суртал, албан тушаалтны ёс зүйн зөрчил гаргасан 21 буюу 12 хувь, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулан ашигласан байж болзошгүй талаар 28 буюу 17 хувь, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан талаар 74 буюу 44 хувийг, албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө орлогын мэдүүлэг шалгуулахаар хандсан 45 буюу 27 хувь нь байна.

Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, түүнийг тайлбарлах замаар мөн урьдчилан сэргийлэх боломжтойг өмнө дурьдсан. Энэ арга замыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 8 дугаар зүйлд зааснаар дараах байдлаар зохицуулсан байна.


Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргаж байгаа тайлбар нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд өмнө танилцуулсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө

орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл өгөх журам"-ын дагуу үүнтэй холбоотой мэдээлэл авах боломж иргэд, байгууллагуудад олгогдсон байна.




Гурав. Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх

Албан тушаалтан албан үүрэгт нь хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг эрх бүхий байгууллагад мэдэгдэх замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлдэг. Албан тушаалтан өөрийн албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээлгэхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.



Харин аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд дараах байдлаар зохицуулсан байна.



Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 4 болон 5 дах хэсэгт дурьдсан арга замуудын талаар бид тус гарын авлагын 1.3 дах хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт” болон “Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт”-аар авч үзсэн тул эргэж нягтлан хараарай.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтан, төрийн байгууллагад үүрэг болгон ногдуулсан байгааг та бүхэн анзаарсан байх. Гэхдээ ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд олон нийтэд нээлттэй байх мэдээллийн тусламжтайгаар иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын оролцоо ч мөн өргөн хүрээнд хуульчлагдсан байгаатай болон үүнийг хэрхэн ашиглах талаар танилцлаа.

Дөрөв. Ашиг сонирхлын зөрчлийн урьдчилсан мэдүүлэг гаргах

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх бас нэгэн аргыг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” тухай хуульд тодорхойлсон байна. Уг хуулиар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд энэхүү гарын авлагын хавсралтад байгаа “Ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын

мэдүүлгийн маягт"-ын дагуу ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргаж томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлдэг байна. Энэхүү урьдчилсан мэдүүлгийг хүлээн авсан этгээд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх бөгөөд тус байгууллагаас ажлын 10 өдөрт багтаан хянан шалгаад "хэрвээ тухайн хүнийг тухайн нийтийн албан тушаалд томилоход" хувийн ашиг сонирхол, нийтийн албан тушаал хоёрын дунд харшилдах ямар нэгэн нөхцөл үүсч болох эсэх талаар дүгнэлт гаргадаг байна. Хэрвээ илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй байдаг. Ингэснээр илт ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд энэ зохицуулалт чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

СУРГАЛТАД АШИГЛАЖ БОЛОХ ДАСГАЛ АЖЛУУД



Дасгал 1.

Оролцогчдыг 5 багт хуваан “Ханын сонин” хийх аргыг ашиглан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн 5 арга зам тус бүрээр ханын сонин хийж, бусад оролцогчиддоо уг арга замыг сурталчлан, таниулах ажлыг хийгээрэй. Ингэхдээ баг тус бүрд 5 том цаас, маркер, өнгийн цаас зэргийг тарааж өгнө. Үүнд дараах 5 сэдвийг 5 баг бүрд хуваарилна.

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоох, мөрдүүлэх
2. Нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах
3. Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх
4. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, энэ тохиолдолд бичгээр зөвлөмж өгөх
5. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд төрийн байгууллагын удирдлага өөрийн удирдлагад ажиллаж байгаа албан тушаалтанг давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.

Дасгал 2.

Оролцогчдыг 2 багт хуваан “Ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ” сэдвээр ухуулгын ажил хийх даалгавар өгнө үү. Эхний баг төрийн албан тушаалтнуудад зориулсан ухуулга, харин нөгөө баг иргэд болон олон нийтэд зориулсан ухуулгын ажил хийх юм.

Дасгал 3.

Оролцогчид өөрсдийн мэдэх ашиг сонирхлын зөрчлийн тодорхой тохиолдол, эсвэл гарын авлагад байгаа зарим бодит баримт, кейс зэргийг ашиглан иргэнийхээ хувиар албан тушаалтны ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой мэдээлэл авах хүсэлтийг холбогдох маягтыг ашиглан бичнэ үү. Түүнчлэн энэ аргыг ашиглан өргөдөл, гомдлыг харьяалах албан тушаалтанд хандан гаргах дасгал ажлыг хийнэ үү.

Дасгал 4.

Сургалтын орчинд интернэт ашиглах боломжтой бол www.хасхот.iaас.mn цахим хуудасны вэбсайтад нэвтэрч ямар төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлдэг талаар жагсаалт гаргаарай. Үүндээ гарын авлагын хавсралтад байгаа “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн загвар, жишээ”-г ашиглана уу.

СЭДЭВТЭЙ ХОЛБООТОЙ ГАРЧ БОЛОХ НИЙТЛЭГ АСУУЛТ, ХАРИУЛТ

Асуулт. Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ямар арга хэмжээ авах үүрэгтэй вэ?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 7.2 дахь хэсэгт төрийн байгууллагын удирдлагын энэ чиглэлээр хүлээх үүргийг заасан байна. Төрийн байгууллагын удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх, уг хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх үүрэгтэй. Хэрэв албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг, мөн түүнчлэн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хянан шалгах явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

Асуулт. Мэдэгдэл гаргахаас гадна ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал үүсвэл хэрхэх вэ?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.2 дахь хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй” хэмээн заажээ. Түүнчлэн ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Албан тушаалтан өөрөө ийнхүү мэдэгдэхээс гадна ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болохоор хуульд заасан.

Асуулт. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Хариулт. Энэ тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Асуулт. Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилтэй байвал тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

Хариулт. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэхийг нэн даруй шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг тухайн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд бичгээр гаргасан тайлбар, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн бичгээр гаргах ёстой.

Асуулт. Ашиг сонирхлын зөрчилтэй талаар мэдэгдсэн атал тухайн албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болох уу?

Хариулт. Ашиг сонирхлын зөрчилтэйгээ мэдэгдсэн атал албан тушаалтныг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.5 дах хэсэгт заасан хоёр тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно. Эдгээр тохиолдол нь 1) Тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан байгууллагаас өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй, 2) Тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно.

Асуулт. Албан тушаалтан албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлын талаар ямар байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх вэ?

Хариулт. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Асуулт. Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хэзээ гаргаж өгөх ёстой вэ?

Хариулт. Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргана. Мэдүүлгээ уг хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэй.

Асуулт. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг ямар байгууллагууд бүртгэж, хадгалах вэ?

Хариулт. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, дээрхээс бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан бүртгэж хадгална.

Асуулт. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй танилцах боломж бий юу?

Хариулт. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй бөгөөд Авлигатай тэмцэх газар, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, бусад албан тушаалтныг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

Асуулт. Хэрэв албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй эрх бүхий байгууллага танилцах боломж олгоогүй бол яах вэ?

Хариулт. Энэ тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Асуулт. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэн хянан шалгах вэ?

Хариулт. Авлигатай тэмцэх газар өөрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгээс бусад хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ. Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно. Улсын Их Хурлын Гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.

Асуулт. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах үүрэг хүлээдэг үү?

Хариулт. Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил эрхлэхээс татгалзах үүрэгтэй.

2.2. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Сэдвийн түлхүүр ойлголт:

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудаас хийж болох тодорхой арга хэмжээний жагсаалт

Сэдвийн хэрэглээ:

- Мэдээлэл өгөх, сургалт явуулах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахад мэдээлэл болгон ашиглах
- Олон нийтийг хамарсан компани т ажил зохион байгуулахад ашиглах
- Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ, мониторинг хийхэд мэдээлэл болгон ашиглах



Авлигаас ангид, шударга нийгмийг байгуулах нь дан ганц төрийн ажил биш юм. Төрийн байгууллагад эрч хүчтэй, хараат бус, бие даасан иргэний нийгмийн байгууллага, тэр дундаа төрийн бус байгууллагын туслалцаа, оролцоо, дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байдаг. Сүүлийн жилүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудалд амжилт олж байгаа нэг хүчин зүйл нь Олон улсын байгууллага, үндэсний засгийн газар, орон нутгийн захиргаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, бие биеэ нөхсөн хүчин чармайлт ¹⁰ юм.

Орчин үеийн иргэний нийгмийн байгууллага дараах үндсэн гурван үүргийг гүйцэтгэж байна.

¹⁰ "Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар". 2008 он. НҮБХХ


1. Бодлого, шийдвэр боловсруулахад оролцох
2. Орон нутгийн иргэдийн байгууллага, үндэсний хэмжээний төрийн бус байгууллагаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх
3. Төр, засгийн газрын байгууллагууд үүрэг амлалтаа биелүүлж байгаа эсэх талаар хяналт тавих.

Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй хүчтэй явуулснаар ашиг сонирхлын зөрчил гэж чухам юу болох, ямар хор уршигтай байдаг талаар ойлголт, мэдлэгтэй болох бөгөөд үүнд хамгийн чухал оролцогч тал нь дээр дурьдсанчлан, иргэний нийгмийн байгууллага, тэр дундаа төрийн бус байгууллага байдаг. Төрийн бус байгууллага бусад аль ч оролцогчдоос илүү энэ асуудалд анхаарлаа хандуулж, үүрэг болон оролцоогоо нэмэгдүүлж байдаг. Тухайлбал,

- Хяналт шинжилгээ хийх
- Оношилгооны судалгаа явуулах
- Олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, энэ чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх, сурталчлах
- Зөрчлийг илрүүлж төр засгийн холбогдох үйл ажиллагаа, шийдвэрүүдэд хяналт тавих
- Ашиг сонирхлын зөрчилтэй, авлигач удирдагч нараас ангижрах ажлыг манлайллаар хангах
- Тодорхой хууль тогтоомж, зохицуулалтыг өөрчлөхийн төлөө олон янзын арга замаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах.

Төрийн бус байгууллагын гол үүрэг бол олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд оршдог бөгөөд энэ сэдвийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой зарим арга замуудын талаар авч үзье.

Нэг. Олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах



Олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх хөтөлбөрийг оновчтой боловсруулах нь өөрөө их төвөгтэй байдаг. Хөтөлбөрийг боловсруулахдаа олон том зорилго тавилгүй, богино хугацаанд хэрэгжиж болох, товч тодорхой, хэмжиж болохуйц зорилго тавих хэрэгтэй. Төрийн бус байгууллагууд олон нийтийн боловсролын



хөтөлбөрүүдээр дамжуулж хүмүүсийг авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох үйл явцад оролцох оролцоог мэдүүлэх, асуудлын учир шалтгаан, муу үр дагавар, түүнээс хувь хүмүүст болон нийгэмд үзүүлэх хор хөнөөлийг мэддэг болгох хэрэгтэй юм. Мөн хөтөлбөртөө дан ганц ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдээлэл олгохоос илүүтэй, түүнтэй холбоотой төрийн албаны ёс зүй, авлигын асуудал зэрэг өргөн хүрээг хамруулсан, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх чиглэлийн үйл ажиллагааг тусгаж болно. Тиймээс олон нийтийн хандлагыг өөрчлөхийн тулд энгийн ойлгомжтой арга хэлбэрийг сонгох хэрэгтэй. Жишээ нь, хувь хүнээс жишээ татсан бодит үйл явдал, эсвэл хүмүүсийн амьдралд ойр дөхөм ашиг сонирхлын зөрчлийн тодорхой түүх, жишээг иш татах нь хамаагүй илүү үр нөлөө үзүүлдэг.

Олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулахдаа дараах зүйлүүдийг заавал тусгах ёстой.

1. Ямар зорилтот бүлэгт чиглэж явуулахаа тодорхойлох

- Нийт хүн ам
- Залуучууд, оюутнууд
- Улс төрчид
- Төрийн бус байгууллагууд
- Бизнесийн байгууллага
- Нийгмийн тодорхой хэсэг гэх мэт.

2. Олон нийтэд ямар мэдээлэл дамжуулахыг хүсч байгаагаа тодорхойлох

- Ашиг сонирхлын зөрчил нь ...
- төрд итгэх итгэлд сэв суулгаж байна
- төрийн өмчийн эх үүсвэрийг хувийн зорилгодоо ашиглаж байна
- төрийн үйлчилгээг танил талдаа үзүүлж байна
- хүмүүст болон нийгэмд хор хөнөөл хүргэж байна
- эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болж байна
- тодорхой хууль тогтоомж бий болгох хэрэгцээ байна



- тусгайлсан хууль тогтоомж гаргах зайлшгүй шаардлагатай гэх мэт.
3. Олон нийтэд хүргэх мэдээллээ хаанаас цуглуулахаа тодорхойлох
- Одоо байгаа сонин хэвлэлээс, сэтгүүлчдээс
 - Олон нийтийн дунд асуулга явуулах
 - Зорилтот бүлэгтэй ажиллаж мэдээлэл авах
 - Төрийн албан тушаалтнуудын дунд асуулга явуулах
 - Төрийн байгууллагуудаас гаргасан статистик тоо баримт, судалгааны тайлан
 - Төрийн бус байгууллага, шинжээчдийн хийсэн судалгааны болон үнэлгээний тайлан
4. Ямар өөрчлөлтийг хүлээж байгаагаа тодорхойлох
- Нийгэм дэх зорилтот бүлгийн ухамсарт өөрчлөлт гарах
 - Төрийн албан хаагчдын хандлага өөрчлөгдөх, тэдний хариуцлагыг дээшлүүлэх
 - Шинэ ур чадвар эзэмших
 - Иргэний нийгэм илүү идэвхтэй оролцох
 - Шинэ хууль тогтоомж гарах
 - Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
5. Мэдээллийг ямар хэрэгсэл ашиглан хэрхэн түгээх вэ гэдгээ тодорхойлох
- Сонин хэвлэл
 - Телевиз, радио
 - Интернэт
 - Кампанит ажил, олон нийтийн жагсаал цуглаан
 - Захидал, танилцуулга, зурагт хуудас
 - Сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага.

Хоёр. Судалгаа явуулах

Төрийн бус байгууллагууд үйл ажиллагааныхаа чиглэл, төсөл, хөтөлбөрийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлийн цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох, эсвэл төрийн байгууллага, албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлийн аль хориглолт, хязгаарлалтыг илүүтэй

зөрчиж байна, хуулийн хэрэгжилт ямар байгаа зэргийг тодруулахын тулд тоон болон чанарын судалгааг иргэд, байгууллагуудын дунд явуулж болно. Ашиг сонирхлын зөрчлийн талаарх тоон болон чанарын судалгааг хийхдээ судалгааны олон аргуудыг өргөнөөр ашиглах боломжтой. Тухайлбал, санал асуулга, ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, ажиглах, баримт бичиг дээр дүн шинжилгээ хийх.



Төрийн бус байгууллагууд хийх судалгааныхаа үндсэн сэдэв, түүний цар хүрээ, үр нөлөө зэрэгт үндэслэн судалгааны арга замаа сонгох хэрэгтэй. Судалгааны зарим аргуудын зорилго, давуу болон сул талын талаарх мэдээлэлд үндэслэн аль аргыг сонгон авахаа тодорхойлж болно. Судалгааны үр дүндээ үндэслэн олон нийтийн мэдлэг, хандлагыг өөрчлөх хөтөлбөр боловсруулах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах эсвэл хэрэгжилтийг хангах дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулах, эсвэл төрийн албан хаагчдад зориулсан сургалтын болон сурталчилгааны ажлын хөтөлбөр боловсруулах боломжтой юм.



Жишээ.

“Ашиг сонирхлын зөрчлийн аль төрөл илүү түгээмэл байна вэ?” гэсэн асуултад төрийн албан хаагчдын 20.4 хувь нь албаны нэр нөлөөгөө хувийн давуу байдлыг бий болгоход ашиглах, 14.6 хувь нь танил тал, найз нөхөддөө давуу эрх олгох, 13 хувь нь шийдвэр гаргахад хувийн эрх ашгийн үүднээс хандах, 12.5 хувь нь төрийн өмчийг хувьдаа хэрэглэх явдал гэжээ. Албаны нэр нөлөөгөө хувийн давуу байдлыг бий болгоход ашиглаж, өөртөө давуу байдал бий болгох үйлдлийг сонирхлын зөрчлийн түгээмэл хэлбэр гэж үзсэн ба ах дүү, танил тал, найз нөхөддөө давуу эрх олгох, шийдвэр гаргахад хувийн эрх ашгийн үүднээс хандах, албан үүргээ гүйцэтгэсний төлөө бэлэг авах, төрийн өмчийг хувьдаа ашиглах зэрэг хэлбэрүүдийг судалгаанд оролцогчид түгээмэл байна гэжээ.

“Төрийн үйл ажиллагааны ямар үйл явцад сонирхлын зөрчил хамгийн ихээр илэрдэг вэ” гэсэн асуултад 64.9 хувь нь төрийн албанд ажилд авахад, 59.2 хувь нь албан тушаал дэвшүүлэхэд, 57.7 хувь нь тендер шалгаруулах, гэрээгээр ажил үүрэг гүйцэтгүүлэхэд, 51.3 хувь нь тусгай зөвшөөрөл олгох болон хураахад, 45.6 хувь нь гадаад дотоодын сургалтанд хамрагдахад илэрч байна гэж хариулжээ.

2009 оны “Төрийн албан дах ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт хандлага” гэсэн судалгааны дүнгээс...

Жишээ.

Төрийн байгууллагууд зөвхөн хээл хахууль авах бус, төрийн байгууллагуудын тэмдэглэлт ой, өдрийг тохиолдуулан элдэв хандив тусламж нэхэх явдал түгээмэл болсон бөгөөд хэрэв өгөхгүй бол янз бүрийн дарамт шахалт үзүүлдэг явдал нэлээд байна. Манай судалгаанд оролцогсдын 31.5 хувь нь төрийн байгууллагуудад авлига, хээл хахууль маш их байдаг гэсэн бол 38.2 хувь нь нилээд хэмжээнд, 48.6

хувь нь бага зэрэг байдаг гэжээ. Өөрөөр хэлбэл, нийт судалгаанд оролцогсдын 92.6 хувь нь төрийн байгууллагуудад авлига, хээл хахууль, элдэв хандив нэхэлт, дарамтууд байсаар байгааг илэрхийллээ.

*“Хүнд суртлын Индекс-2009” судалгаа Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Тамхим, 2009*

Гурав. Зорилтот бүлгүүдэд хандсан тусгай сургалт зохион байгуулах

Нийгмийн тодорхой хэсгүүдэд хандсан тусгай сургалтуудыг зохион байгуулах нь олон хүмүүсийг хамарсан кампанит ажлаас илүү үр дүнтэй байдаг. Яагаад гэвэл, сургалтын хэрэгцээг тодорхойлон тодорхой бүлэг хүмүүст сургалтыг явуулснаар оролцогчдын мэдлэг дээшлэх, хандлага өөрчлөгдөх боломж



зэрэг бүрддэг. Жишээлбэл: Үйлчилгээ хөнгөвчлөх төлбөр, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? түүний хор нөлөө, ашиг сонирхлын зохицуулалт бидний амьдралд нөлөөлдөг үү зэрэг сэдвүүдээр багийн иргэд, багш нар, залуучууд эсвэл ахмадуудад заах уу гэдгээ тодорхойлсны дараа тэдний дунд сургалтаа зохион байгуулснаар оролцогчдын мэдлэг, хандлагыг өөрчилж, тэднээр дамжуулан бусад хүмүүст мэдээлэл хүргэх давхар ач холбогдолтой юм. Түүнчлэн, төрийн албан тушаалтнуудад ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, өөрийгөө ашиг сонирхлын зөрчилтэй байдалд орохоос хэрхэн хамгаалах, орсон тохиолдолд явал зохистой талаарх мэдээллийг сургалтаар дамжуулан хүргэх боломжтой.

Жишээ.

Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөнөөс Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн байгууллагад шинээр томилогдсон албан тушаалтнуудад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг ойлгож, хэрэглэх нь” сэдэвт сургалтыг 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан.

Дөрөв. Олон нийтийн мэдээллийн кампанит ажил зохион байгуулах

Хүмүүст ашиг сонирхлын зөрчлийн талаар явуулж буй үйл ажиллагаанд оролцож буй тэдний хүчин чармайлт талаар болоогүй, тэдний үйл ажиллагаа тодорхой нөлөө үзүүлж байгаа гэдгийг мэдрүүлэх шаардлагатай байдаг. Олон нийтийн



мэдээллийн кампанит ажил нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанаас гарсан тодорхой үр дүнг хөндөж, өөрчлөлтийн бодит боломжийг онцлон харуулахад маш сайн нөлөө үзүүлдэг.

Олон нийтийн мэдээллийн кампанит ажлаар өргөн хүрээний зорилготой үйл ажиллагааг сурталчлахаас гадна бага багаар хийгдэж буй өөрчлөлтийн ач холбогдлыг сурталчлах хэрэгтэй байдаг. Ийм үйл ажиллагаанд дараах арга хэмжээнүүдийг багтааж болно.

- Сурталчилгааны сонин, хэвлэмэл материал хэвлэж тараах
- Өдөр тутмын сонин, сэтгүүлээр дамжуулан ашиг сонирхлын зөрчлийн талаар цуврал мэдээлэл хүргэх
- Телевизийн болон фм радиогийн реклам сурталчилгааг ашиглах
- Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах.

Тав. Телефон утасны шуурхай алба ажиллуулах

Бухимдсан иргэд гомдлоо илэрхийлдэг телефон шуурхай албыг олон улсын түвшинд ихээр ажиллуулдаг байна. Энэ шуурхай алба 24 цагаар болон ажлын өдрүүдэд, ажлын цагаар ажиллаж болох бөгөөд оператор буюу хариулагч машин асуултыг хүлээн авдаг. Төрийн бус байгууллагууд шуурхай алба ажиллуулбал дараах зүйлийг анхааралдаа авах ёстой.

- Иргэдийн эрх ашгийг хамгаалах албаны үүрэг болон шуурхай алба чухам хэнд зориулагдсан бэ гэдгийг нарийвчлан томъёолох
- Шуурхай алба нь ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтыг сайжруулах илүү өргөн хүрээний стратегийн хэсэг гэдгийг санах
- Энэхүү үйлчилгээний зорилго болон хэн эрхэлж байгааг тайлбарласан оновчтой сурталчилгаа хийх
- Үйлчилгээ нь итгэл найдвар төрүүлсэн байх
- Нэргүй мэдээллийг хэзээ, ямар тохиолдолд хүлээж авах талаар тодорхой, ойлгомжтой зааварчилгаа гаргах

- Утсаар ярьж байгаа хүмүүсийн эрх үүргийг тайлбарлах хийгээд тэдний асуудлыг шийдвэрлэх ерөнхий арга замыг хэлж өгөх чадвартай, сайтар бэлтгэгдсэн, туршлагатай операторуудыг ажиллуулах
- Нэрээ хэлж ярьсан хүмүүст тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгддэг байх.

Зургаа. Интернет ашиглаж мэдээлэл түгээх



Дэлхийн олон улс оронд засгийн газрын цахим хуудсууд бий болж илүү их мэдээллийг урьд өмнө нь байгаагүй хялбар аргаар олж авах боломж иргэдэд нээгдсээр байна. Зарим улсад өмнө нь зөвхөн хуульчид танилцах эрхтэй байсан хууль тогтоомжийг анх удаа иргэд нь цахим хуудсаар дамжин бүрэн хэмжээгээр чөлөөтэй үзэх боломжтой болжээ. Манай улсад ч энэ дэлгэрсэн арга бөгөөд Авлигатай тэмцэх газрын цахим хуудас болон зарим төрийн бус байгууллагууд өөрсдийн цахим хуудсаараа дамжуулан ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх мөн ухуулга сурталчилгааны ажлууд зохион байгуулж байна.

Жишээ.

“Зориг сан” төрийн бус байгууллага нь авлигын эсрэг “www.anticorruption.mn” хаягтай анхны цахим хуудас хийж байршуулжээ. Авлигын сэдвээр гарсан материал, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдийн товхимол, танин мэдэхүйн материалуудыг уг вэб хуудсанд багтаасан байна.

www.хасхот.iaас.mn цахим хуудсанд иргэд хандан төрийн өндөр албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцах боломжтой болсон.

Долоо. Олон нийтийг хамарсан кампанит ажил



Иргэний нийгмийн байгууллагууд нөхцөл байдлыг хяналтандаа авах хэрэгтэй. Нэгэнт хийж чадна гэдгээ мэдсэн л бол хийхийг улам ихээр хүсэх болно. Энд хүний нүдэнд харагдахуйц амжилтын түүхүүд чухал үүрэг гүйцэтгэх боловч үндэсний хэмжээний үйл явдлууд ч эв нэгдлийг илтгэн харуулж чадна. Жагсаал цуглаан, олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөн, үндэсний хэмжээний үйл явдлууд нь өөртөө итгэх итгэлийг бататгаж, эв нэгдлийн мэдрэмж төрүүлэхийн зэрэгцээ төрийн албан тушаалтнуудад бодож эргэцүүлэх зүйл гаргаж өгдөг.

Бүхий л кампанит ажлуудад байдаг шиг сонин содон, уран сэтгэмжтэй, нүдэнд харагдахуйц үйл явдал зохион байгуулж олны анхаарлыг татах нь олон нийтийг татан оролцуулж, өөрчлөлтийн хүчирхэг хөдөлгөгч хүч бий болгох үр дүнтэй хэрэгсэл байж болно. Уганда Улсад гудамжны театр, явуулын жүжгийн бригад ажиллуулах нь үр дүнтэй арга байсан бол зарим улсад “Авлигатай тэмцэх өдрүүд” зохион байгуулах нь олон нийтийн оролцоог илүүтэй татдаг, зарим улсад сонгуулийн кампанит ажлын үеэр улс төрчдөөр “Ашиг сонирхлын зөрчилтэй аливаа шийдвэр гаргахад оролцохгүй байх, ийм үйлдэлтэй тэмцэх амлалт” авахуулах кампанит ажил зохион байгуулж байна.

Найм. Хяналт шинжилгээ, мониторинг хийх



Хяналт шинжилгээний ажил идэвхтэй явуулахад олон нийтийг татан оролцуулж болох хоёр арга зам байдаг. Эхнийх нь маш ерөнхий байдалтай буюу хүмүүс өдөр тутмын амьдралдаа тулгарч буй дутагдал доголдлуудыг байнга ажиглаж анхаарал тавьж байхыг хөхиүлэн дэмжих явдал байдаг. Хяналт шинжилгээний хоёр дах арга нь замын цагдаа нарын хээл хахууль,

хувьчлалын тодорхой жишээ, төрийн албан тушаалтнуудын авлигатай тэмцэх амлалт зэрэгт байнга хяналт тавьж байвал зохих газруудыг тогтоож өгдөг. Хяналт шинжилгээг нийгмийн бүх гишүүдийн эсвэл зөвхөн цөөн тооны сайн дурынхны оролцоо, дэмжлэгтэйгээр хийж болно. Хяналт шинжилгээ хийх хүмүүс, байгууллагыг хяналт шинжилгээ хэрхэн хийх чиглэлээр сургалтад хамруулж бэлтгэх хэрэгтэй. Сургалтад хамрагсад нь мониторингийн чиглэлээр мэдлэгтэй болохоос гадна тухайн хууль тогтоомжийн зохицуулалтын онцлог, асуудлын гол агуулга, зарчим, бусад улсад хүлээн зөвшөөрөгдсөн практикуудыг судлах хэрэгтэй юм.

Жишээ.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар орон нутаг дах авлигаас урьдчилан сэргийлэх төрийн бус байгууллагын сүлжээний гишүүн байгууллагууд аймгийнхаа төрийн үйлчилгээний ил тод байдалд мониторинг хийж байгаа билээ. Дэлхийн банкны санхүүжилтээр хийж буй энэхүү төслийг хэрэгжүүлэх эрхийг авсан Өвөрхангай аймаг дах авлигаас урьдчилан сэргийлэх төрийн бус байгууллагуудын сүлжээнийхэн идэвхтэй ажиллаж байна.

Мониторингийг Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, мөн Хужирт, Хархорин сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хийхээр сонгож авчээ. Тус байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төсөв санхүүгийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлын өнөөгийн түвшинг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлох зорилгоор Засгийн газрын 143 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн үнэлгээ хийж байна. Энэ хүрээнд дээрх байгууллагуудаар үйлчлүүлдэг иргэдээс санал асуулга авах, түүвэр болон фокус бүлгийн ярилцлага хийх, эрх зүйн актуудыг цогц байдлаар судлах, албаны хүмүүсийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, төслийн явцыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар

Ес. Нөлөөллийн үйл ажиллагаа явуулах

Нөлөөлөл бол хүмүүсийн хандлагыг өөрчлөхөд чухал үр нөлөө үзүүлдэг арга юм. Нөлөөлөл гэдэг нь зөвхөн хувь хүний хувьд дангаараа бус, нийгмийн бусад гишүүдийг төлөөлж эсвэл тэдэнтэй хамтран олон нийтийг аливаа үйлдэлд уриалан дуудах явдал байдаг. Нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд төрийн албан тушаалтнууд олон нийтийн хараа хяналтад байгаагаа болон шударга бус үйлдэлд оролцвол хариуцлага хүлээнэ гэдгээ мэдэрч эхэлдэг.

Жишээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага нь төрийн байгууллагаас мэдээлэл авах боломжийг сайжруулан авлигатай тэмцэх, ил тод, хариуцлагатай засгийн газрыг дэмжих зорилготой “Мэдээлэл авах боломжийг сайжруулан авлигатай тэмцэх нь” төслийг 2008 онд хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд Мэдээллийн эрх чөлөөний хуулийг шинээр, Төрийн нууцын тухай хуулийг шинэчлэн батлуулахын төлөө нөлөөллийн болон лобби ажиллагаа явуулсан байна. Уг нөлөөллийн кампанит ажилдаа иргэний нийгмийн байгууллагуудыг эвсэл хэлбэрээр татан оролцуулжээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага



Арав. Шог зургаар дамжуулж сурталчилгаа явуулах

Төрийн бус байгууллагууд, иргэд, оюутан сурагчдын дунд зохицуулаагүй, хязгаарлаагүй ашиг сонирхлын зөрчлийн хор хөнөөл, үр дагаврыг илэрхийлэх, үүний эсрэг олон нийтийг уриалан дуудах зэрэг зорилгоор шог зургийн уралдаан зарлаж олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулж болно. Хамгийн гол нь шог зургаар ямар мессежийг олон нийтэд хүргэх гэж байгаа зорилгоо уралдаанд оролцох хүмүүст тодорхой зарлах ёстой. Олон нийтэд мэдээлэл өгөх, тэдэнд нөлөөлөх үйл ажиллагаанд шог зургийг ашиглах нь маш чухал үр нөлөө үзүүлдэг. Шог зургийг сонин, сэтгүүл, вэб хуудас, зурагт хуудсанд байрлуулах эсвэл дангаар нь хэвлэн нийтлэх хэлбэрээр олон нийтэд хүргэж болно. Мөн төрийн бус байгууллагууд шог зургаар дамжуулан олон хүмүүс, байгууллагуудад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулъя гэвэл хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй болно.

СУРГАЛТАД АШИГЛАЖ БОЛОХ ДАСГАЛ АЖЛУУД



Дасгал 1.

Танай байгууллага цахим хуудас ашиглан “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” сурталчилгаа явуулах болжээ. Энэ тохиолдолд танай байгууллага цахим хуудсан дээрээ ямар мэдээллүүд багтаах вэ? Оролцогчид багт хуваагдан цахим хуудасны нүүр хуудас буюу ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийн жагсаалтыг зургийн хамт боловсруулна.

Дасгал 2.

Олон нийтийг хамарсан кампанит ажил нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулдаг арга юм. Та бүхэн уул уурхайн зөвшөөрлийг хууль журмын дагуу олгодоггүй, томоохон бизнесийн компаниудаас их хэмжээний хандив авч байж зөвшөөрөл олгодог орон нутгийн засаг захиргааны хэргийг олон нийтэд ойлгуулж таниулах ажил хийхээр Баянхонгор аймгийн нэгэн суманд иржээ гэж төсөөлнө үү. Ингээд дүр тоглох аргыг ашиглан гудамжны театр ажиллуулан нутгийн иргэдэд ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар сурталчилгаа хийнэ үү. Сургалтад оролцогчид дүр тоглолтын сценариа боловсруулж, түүнийхээ дагуу дүрээ хуваарилан жүжгээ бэлтгэж, бусад оролцогчиддоо тоглож үзүүлнэ. Дүр аваагүй оролцогчид жүжгийг үзэж, өөрсдийн дүгнэлтээ бичнэ.

Дасгал 3.

Дархан-Уул аймгийн багийн иргэдийн дунд ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлууд буурахгүй байх шалтгаан, түүний үр дагавар, тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгаа талаар мэдээлэл авах зорилгоор фокус бүлгийн ярилцлага хийнэ үү? Эхлээд оролцогчдоос асуух асуулуудаа боловсруулна.

Дараа нь ярилцлагыг чиглүүлэгч, ярилцлагад оролцогчдыг сонгоно. 20 минутын хугацаанд ярилцлагыг өрнүүлж, ярилцлагын дүгнэлтийг бичнэ.

Дасгал 4.

Та өөрийгөө Монголын үндэсний телевизийн сэтгүүлч гэж эхлээд төсөөлж бодно уу. Авлигатай тэмцэх олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан танай телевиз бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Ашиг сонирхлын зөрчил - Арын хаалга” сэдвээр иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулахаар болсон байна. Та уг асуудлыг хариуцан авсан сэтгүүлчийн хувьд хэлэлцүүлгийг чиглүүлэх асуултууд боловсруулах даалгавар авчээ. Ямар асуултууд байж болох вэ? Та жагсааж бичсэн асуултын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтад оролцогчдоо татан оролцуулаарай.

Дасгал 5.

Нэгэн өдөр тутмын сонин “Ашиг сонирхлын зөрчил үү?” сэдвийн хүрээнд зурагт хуудасны уралдааныг сонинуудын дунд зарлажээ. Та өөрийнхөө ажилладаг сониныг төлөөлөн уралдаанд оролцох үүрэг даргаасаа авчээ гэж бодвол уг сэдвийн хүрээнд та ямар зурагт хуудас бүтээх вэ? Зурж үзүүлнэ үү.

Дасгал 6.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг нэгэн ТББ фм радионуудын дунд “Ашиг сонирхлын зөрчил” сэдвийн хүрээнд хамгийн ойлгомжтой бөгөөд товч тодорхой уриа буюу мессеж боловсруулах уралдаан зарлажээ. Та фм радиод ажилладаг хүний хувьд уг уралдаанд оролцвол ямар мессеж боловсруулах вэ?

